

**ТӨРЛӨӨР УСТГАХ ГЭМТ ХЭРЭГ, ХҮН ТӨРӨЛХТНИЙ ЭСРЭГ
ГЭМТ ХЭРЭГ, ДАЙНЫ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ОЛОН УЛСЫН
БУСАД ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛААР ОЛОН УЛСАД ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ ЛЮБЛЯНА-ГААГИЙН КОНВЕНЦ**

Монгол Улсын Гадаад харилцааны яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН


Гарын үсэг /Signature/



2024 оны 4 сарын 9 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Foreign Affairs of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Агуулга	5
Удиртгал	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
1 дүгээр зүйл. Конвенцын зорилго	7
2 дугаар зүйл. Конвенцын хамрах хүрээ	7
3 дугаар зүйл. Тайлбарлах үндсэн зарчим	7
4 дүгээр зүйл. Бусад гэрээ, хэлэлцээртэй харилцан хамаарал	7
5 дугаар зүйл. Олон улсын гэмт хэргийн нэр томъёоны тодорхойлолт	8
6 дугаар зүйл. Энэхүү конвенцын нэмэлт хэрэглээ	15
7 дугаар зүйл. Гэмт хэрэгт тооцох	15
8 дугаар зүйл. Гэмт хэргийн харьяалал	15
9 дүгээр зүйл. Харьят	16
10 дугаар зүйл. Хамтын ажиллагааны үндсэн зарчим	16
11 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа	16
12 дугаар зүйл. Гомдол гаргах эрх	17
13 дугаар зүйл. Урьдчилсан арга хэмжээ	17
14 дүгээр зүйл. Aut dedere, aut iudicare зарчим	17
15 дугаар зүйл. Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага	18
16 дугаар зүйл. Хувийн мэдээлэл ашиглах болон хамгаалах	18
17 дугаар зүйл. Мэдээлэл шууд солилцох	20
18 дугаар зүйл. Зардал	21
19 дүгээр зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх болон	21
Шилжүүлэн өгөхтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолт	21
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭРХ БҮХИЙ ТӨВ БАЙГУУЛЛАГА БА	23
ХООРОНДЫН ХАРИЛЦАА	23
20 дугаар зүйл. Эрх бүхий төв байгууллага	23
21 дүгээр зүйл. Харилцах суваг ба холбоо барих нэг харилцагчтай байх	23
22 дугаар зүйл. Хүлээн зөвшөөрөгдөх хэл	24
ГУРАВДУГААР БҮЛЭГ	25
ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ	25
23 дугаар зүйл. Гуравдугаар бүлгийн хамрах хүрээ	25
24 дүгээр зүйл. Хүсэлтийн зорилго	25
25 дугаар зүйл. Хүсэлт болон хавсаргах баримт бичиг	26
26 дугаар зүйл. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн нууцлал	26
27 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ	26
28 дугаар зүйл. Нэмэлт мэдээлэл	27



30	дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл	27
31	дүгээр зүйл. Мэдээлэл, нотлох баримт дамжуулах,	29
	ашиглахтай холбоотой хязгаарлалт	29
32	дугаар зүйл. Хүсэлтийг гүйцэтгэх	29
33	дугаар зүйл. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсад мэдүүлэг авах	30
34	дүгээр зүйл. Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулах	30
35	дугаар зүйл. Хүсэлт гаргасан оролцогч улсад хүн байлцуулах	32
36	дугаар зүйл. Саатуулагдсан этгээдийг түр хугацаагаар шилжүүлэх	32
37	дугаар зүйл. Аюулгүй байдал	33
39	дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга хэмжээ	34
40	дүгээр зүйл. Мөрдөн шалгах нууц ажиллагаа	34
41	дүгээр зүйл. Хамтарсан ажлын хэсэг	35
42	дугаар зүйл. Хил дамнасан ажиглалт	37
43	дугаар зүйл. Албан тушаалтны хүлээх эрүүгийн хариуцлага	38
44	дүгээр зүйл. Албан тушаалтны хүлээх иргэний хариуцлага	39
45	дугаар зүйл. Хураан авах асуудлаарх олон улсын хамтын ажиллагаа	39
46	дугаар зүйл. Нөхөн олговор	41
47	дугаар зүйл. Хураагдсан хөрөнгийг захиран зарцуулах	41
48	дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэх	42
49	дүгээр зүйл. Дөрөвдүгээр бүлгийн хамрах хүрээ	43
50	дугаар зүйл. Шилжүүлэн өгөх эрх зүйн үндэслэл	43
52	дугаар зүйл. Тусгаарлах зарчим	46
53	дугаар зүйл. Гуравдагч улс уруу дахин шилжүүлэх	46
54	дүгээр зүйл. Харьяатыг шилжүүлэн өгөх	46
55	дугаар зүйл. Хүсэлтийг гүйцэтгэх	47
56	дугаар зүйл. Хүсэлт болон хавсаргах баримт бичиг	47
64	дүгээр зүйл. Эд хөрөнгө хүлээлгэн өгөх	51
65	дугаар зүйл. Шилжүүлэн өгөх этгээдийг дамжин өнгөрүүлэх	52
	ТАВДУГААР БҮЛЭГ. ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ	53
66	дугаар зүйл. Тавдугаар бүлгийн хамрах хүрээ	53
	болон ялтан шилжүүлэхтэй холбоотой нэр томъёоны	53
	тодорхойлолт	53
67	дугаар зүйл. Шилжүүлэх нөхцөл	53
68	дугаар зүйл. Мэдээлэл өгөх үүрэг	54
69	дүгээр зүйл. Хүсэлт, хүсэлтийн хариу, хавсаргах баримт бичиг	55
70	дугаар зүйл. Зөвшөөрөл болон түүнийг хянан шалгах	56



71 дүгээр зүйл. Ял оноосон оролцогч улсыг орхин гарсан этгээд.....	56
72 дугаар зүйл. Албадан, эсхүл нэн даруй гаргах	57
шаардлагатай байгаа ялтан.....	57
73 дугаар зүйл. Ялтан шилжүүлэхэд ял оноосон оролцогч улсын хувьд	58
үүсэх үр дагавар	58
74 дүгээр зүйл. Ялтан шилжүүлэхэд ял эдлүүлэх оролцогч улсын.....	58
хувьд үүсэх үр дагавар.....	58
75 дүгээр зүйл. Ялыг үргэлжлүүлэн албадан хэрэгжүүлэх	59
76 дугаар зүйл. Ялыг хөрвүүлэн тооцох	59
77 дугаар зүйл. Ялын тогтоолыг эргэн харах	60
78 дугаар зүйл. Ялыг албадан хэрэгжүүлэхийг зогсоох	60
79 дугаар зүйл. Ялыг албадан хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл	60
80 дугаар зүйл. Ялтан этгээдийг дамжин өнгөрүүлэх.....	60
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОХИРОГЧ, ГЭРЧ, ШИНЖЭЭЧ БОЛОН БУСАД ЭТГЭЭД	62
81 дүгээр зүйл. “Хохирогч” нэр томъёоны тодорхойлолт	62
82 дүгээр зүйл. Хохирогч, гэрч, шинжээч болон бусад этгээдийг хамгаалах ..	62
83 дугаар зүйл. Хохирогчийн эрх	63
ДОЛООДУГААР БҮЛЭГ : ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	64
84 дүгээр зүйл. Оролцогч улсын уулзалт	64
85 дугаар зүйл. Шилжилтийн үеийн дэмжлэг	64
НАЙМДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД	66
86 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх.....	66
87 дугаар зүйл. Конвенцын нэмэлт, өөрчлөлт	66
88 дугаар зүйл. Нэмэлт хавсралт батлах.....	67
89 дүгээр зүйл. Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох	67
90 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох	68
91 дүгээр зүйл. Түр хугацаагаар хэрэгжүүлэх.....	68
92 дугаар зүйл. Тайлбар хийх	69
93 дугаар зүйл. Конвенцоос гарах	69
94 дүгээр зүйл. Эх хадгалагч болон хэл	69
Хавсралт.....	72



Удиртгал

Энэхүү конвенцын оролцогч улсууд

Энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах олон улсын гэмт хэрэг нь олон улсын хамтын нийгэмлэгийг бүхэлд нь түгшээж буй хамгийн онц ноцтой гэмт хэргийн тоонд багтаж буйг **сануулж**,

Эдгээр гэмт хэргийн ял шийтгэл завших явдалтай тэмцэх нь энх тайван, тогтвортой байдал, шударга ёс ба хууль дээдлэх ёсыг хангахад чухал ач холбогдолтой гэдгийг **цохон тэмдэглэж**,

Улс орнууд энэхүү конвенцод хамаарах олон улсын гэмт хэргийг мөрдөн шалгаж, эдгээр гэмт хэрэг үйлдсэн байх болзошгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх үндсэн үүрэгтэй бөгөөд эдгээр улс орон энэ үндсэн үүргээ бүрэн биелүүлэх нөхцөлөө бүрдүүлэх эрмэлзэлтэй байгаагаа нотлон харуулах үүднээс хууль тогтоомжийн болон захиргааны шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой болохыг **тэмдэглэж**,

Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны болон олон улсын бусад гэмт хэргийн ялыг завших явдалтай тэмцэх чиглэлээр олон улсын эрх зүйг хөгжүүлэхийг **эрмэлзэж**,

Хүмүүнлэгийн эрх зүй, хүний эрх, дүрвэгсдийн эрх зүй болон үүний дотор “эргүүлэн буцаахгүй байх” зарчим зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд улс орнуудын хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг **дахин нотолж**,

Энэхүү конвенцын үйлчлэх хүрээнд хамаарах олон улсын гэмт хэрэгт холбогдсон хохирогч, гэрч болон бусад этгээдийн эрхийг, шүүх ажиллагаанд тэдний гүйцэтгэх үүрэг чухал болохыг, тэдний бие махбод, сэтгэл санааны эрүүл байдлыг хамгаалах шаардлагатай болохыг, тэднийг эсэн мэнд үлдээхэд чиглэгдсэн арга барилыг нэвтрүүлэхийг, шударга шүүхэд хандах болон шаардлагатай бол хохирол барагдуулах шүүх ажиллагааны дагуу зохих нөхөн олговор авах боломж бүрдүүлэхийг **хүлээн зөвшөөрч**,

Мөн гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд хэргээ шүүх ажиллагааны бүх шатанд шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй болохыг **хүлээн зөвшөөрч**,

Эдгээр олон улсын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаа нь гол төлөв тухайн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа улсын нутаг дэвсгэрээс гадна орших сэжигтэн, гэрч, нотлох баримт, эсхүл өмчтэй холбоотойгоор явагддаг болохыг **ажиглаж**,



Үндэсний хүрээнд явагдах эдгээр олон улсын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй болгоход олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай болохыг **хүлээн зөвшөөрч**,

Улс хоорондын харилцаанд хүлээсэн үүрэг болон дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх эрүүгийн хэргийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагаа нь гэмт хэргийн ял завших явдалтай тэмцэх талаар улс орнуудын зүгээс үргэлжлүүлэн гаргах хүчин чармайлтын үндэс суурь болохыг нь **хүлээн зөвшөөрч**, энэ хүчин чармайлтыг бүх түвшинд үргэлжлүүлж, бэхжүүлэхийг **дэмжин**,

Тусгаар улсууд эрх тэгш байх, улсын нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх, бусад улсын дотоод хэрэгт үл оролцох зарчмыг **дахин нотолж**,

Олон улсын зан заншлын эрх зүй болон “Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчийг шийтгэх тухай конвенц”, “Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенц”, “Тэнгисийн цэргийн шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенц”, “Дайнд олзлогсодтой харьцах тухай Женевийн конвенц”, “Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн конвенц” болон түүний нэмэлт протоколууд, “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай конвенц” болон түүний нэмэлт протоколууд, “Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм” зэрэг олон талт баримт бичгийн зүйл заалтад төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийн ял завших явдалтай тэмцэх тухай тусгагдсан болохыг **сайшаан тэмдэглэн**,

Хүн төрөлхтний ухамсрыг цочроосон, төсөөлшгүй аймшигт зэрлэг үйлдэл 20, 21 дүгээр зуунд гарч, үүнд олон сая хүний амь сүйрснийг **эргэн санаж**,

Энэхүү конвенцын үйлчлэлд хамаарах олон улсын гэмт хэргийг илүү үр дүнтэйгээр мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэх **эрмэлзэлтэй байгаагаа нотолж**, энэ чиглэлээр хамтран ажиллахтай холбоотой олон улсын эрх зүйн орчныг бэхжүүлэх шаардлагатай байгааг **хүлээн зөвшөөрч**,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. Конвенцын зорилго

Энэхүү конвенцын зорилго нь төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэрэгт хүлээлгэх ял шийтгэлийг завших явдалтай тэмцэхийн тулд оролцогч улсуудын хооронд эрүүгийн асуудлаарх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Конвенцын хамрах хүрээ


1. Оролцогч улсууд энэхүү конвенцыг 5 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэглэнэ.
2. Улс бүр энэхүү конвенцод гарын үсэг зурахдаа, эсхүл түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах, нэгдэн орох баримт бичгийг хадгалуулахаар өгөхдөө, эсхүл үүний дараа энэхүү конвенцын нэмэлт хавсралтын жагсалтад орсон нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийн тухайд оролцогч нөгөө улстай харилцахдаа энэхүү конвенцын заалтыг хэрэглэх талаар эх хадгалагчид бичгээр мэдэгдэнэ. Ингэхдээ оролцогч нөгөө улс энэхүү конвенцын бүрэлдэхүүн хэсэг болох нэмэлт хавсралтын жагсаалтад орсон ижил төрлийн гэмт гэргийн тухайд энэхүү конвенцын заалтыг нэгэн адил хэрэглэнэ.

3 дугаар зүйл. Тайлбарлах үндсэн зарчим

Энэхүү конвенцыг түүнд хамаарах гэмт хэргийн тодорхойлолтыг оруулсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа, эсхүл боловсруулах шатанд байгаа олон улсын эрх зүйн зарчмыг ямар нэгэн байдлаар хязгаарлаж, эсхүл түүнд нөлөөлөхгүйгээр тайлбарлана.

4 дүгээр зүйл. Бусад гэрээ, хэлэлцээртэй харилцан хамаарал

Энэхүү конвенцын хамрах хүрээний асуудлаар өөр хоорондоо өмнө хэлэлцээр байгуулсан, эсхүл бусад хэлбэрээр харилцаа тогтоосон оролцогч улсууд ийм хэлэлцээр, эсхүл харилцааг хэрэгжүүлэхдээ энэхүү конвенцын заалтыг орлуулж, энэ нь тэдний хамтын ажиллагааг хөнгөвчилж байгаа тохиолдолд энэхүү конвенцын заалт үүнийг хязгаарлахгүй.



5 дугаар зүйл. Олон улсын гэмт хэргийн нэр томъёоны тодорхойлолт


1. Энэхүү конвенцод заасан “төрлөөр устгах гэмт хэрэг”-ийг үндэстэн, угсаатан, арьсны өнгө, эсхүл шашны бүлгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн устгах зорилгоор үйлдсэн дараах үйлдлийг ойлгоно. Үүнд:
 - a) дээрх бүлгийн гишүүдийг алах;
 - b) дээрх бүлгийн гишүүдийн биед хүнд гэмтэл учруулах, эсхүл сэтгэцэд хохирол учруулах;
 - c) дээрх бүлгийн амьдрах нөхцөлд хохирол учруулах замаар бүгдийг нь, эсхүл хэсгийг нь устгалд хүргэх;
 - d) дээрх бүлгийн хүүхэд төрөлтийг зогсоох арга хэмжээ авах;
 - e) дээрх бүлгийн хүүхдүүдийг өөр бүлэгт хүчээр шилжүүлэх.
2. Энэхүү конвенцын заасан “хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг”-ийг халдлага гэдгийг мэдсээр байж иргэдийн эсрэг өргөн хүрээний, эсхүл үе шаттайгаар халдах дараах үйлдлийг ойлгоно. Үүнд:
 - a) хүн алах,
 - b) устгах;
 - c) боолчлох;
 - d) хүн амыг албадан, эсхүл хүч хэрэглэж нүүлгэн шилжүүлэх;
 - e) хорих, эсхүл олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээг зөрчин бусад аргаар шилжих хөдөлгөөнийг ноцтой хязгаарлах;
 - f) эрүү шүүлт тулгах;
 - g) хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, хүчээр бие үнэлүүлэх, албадан жирэмслүүлэх, эсхүл бусад хэлбэрийн бэлгийн хүнд хүчирхийлэл үзүүлэх;
 - h) улс төр, гарал үүсэл, иргэншил, угсаатан, соёл, шашин, хүйс болон бусад үндэслэлээр нэгдсэн, эсхүл санал нийлсэн бүлэг этгээдийг энэ хэсэг болон конвенцод заасан бусад гэмт хэрэгт олон улсын эрх зүйгээр зөвшөөрөгдөхгүй гэж нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үндэслэлээр хэрэгт холбогдуулан шалгах;



- i) хүнийг хүчээр алга болгох;
- j) арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах;
- k) хүний бие, эрүүл мэнд, сэтгэцэд санаатайгаар асар ихээр тарчлаан зовоох, эсхүл ноцтой хохирол учруулахад чиглэсэн ижил төстэй, хүнлэг бус бусад үйлдэл.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан:

- a) “иргэдийн эсрэг чиглэсэн халдлага” гэж төрийн, эсхүл байгууллагын халдлага үйлдэх бодлогоор, эсхүл тухайн бодлогыг ахиулах зорилгоор 2 дахь хэсэгт заасан иргэдийн эсрэг хэд хэдэн үйлдлийг ойлгоно;
- b) “устгах” гэж иргэдийн зарим хэсгийг устгах зорилгоор санаатайгаар амьдрах нөхцөл, тухайлбал хоол хүнс, эм тангаас тасалдуулахыг ойлгоно;
- c) “боолчлох” гэж хүнийг өмчлөхтэй холбоотой бүх төрлийн, эсхүл зарим төрлийн эрх мэдлийг хэрэгжүүлэх, үүнд эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдахтай холбоотой эрх мэдэл хэрэгжүүлэх явдал орно;
- d) “иргэдийг албадан, эсхүл хүчээр нүүлгэн шилжүүлэх” гэж олон улсын эрх зүйгээр зөвшөөрөгдөөгүй үндэслэлээр хүмүүсийг хууль ёсоор оршин байгаа газраас албадан, эсхүл өөр бусад албадлагын аргаар өөр байршуулахыг ойлгоно;
- e) “эрүү шүүлт тулгах” гэж хэрэгт холбогдон саатуулагдсан, эсхүл хяналтад орсон этгээдийн биеэ болон сэтгэцийг санаатайгаар өвдөх, эсхүл зовоохыг ойлгох бөгөөд хууль ёсны шийтгэлээс, эсхүл түүнээс болж өвдөх, эсхүл зовох явдал эрүү шүүлт тулгахад орохгүй;
- f) “албадан жирэмслүүлэх” гэж үндэс угсаанд нөлөөлөх, эсхүл олон улсын эрх зүйн ноцтой зөрчил үйлдэх замаар эмэгтэй хүнийг хүчээр жирэмслүүлэхийн тулд хорихыг ойлгоно. Тухайн тодорхойлолт нь жирэмслэхтэй холбоотой дотоодын хууль тогтоомжид нөлөөлөхгүй;
- g) “ялгаварлан гадуурхаж шалгах” гэж бүлэг, эсхүл санаа нийлсэн бүлгийг олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн эрхийг санаатайгаар ноцтой зөрчихийг ойлгоно;
- h) “арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах” гэж шинж чанараар энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсантай адил үйлдлүүд байх бөгөөд арьсны нэг өнгө бүхий бүлгээс арьсны өөр өнгө бүхий бүлгийг байнга дарлах, ноёрхох,



эсхүл тухайн дэглэмийг хадгалах зорилгоор үйлдсэн хүнлэг бус үйлдлийг ойлгоно;

- i) “хүнийг хүчээр алга болгох” гэж төрийн, эсхүл улс төрийн байгууллагын зөвшөөрөл, дэмжлэг, саналаар хүнийг баривчлах, саатуулах, хулгайлахыг ойлгох бөгөөд ингэхдээ урт хугацаанд тухайн хүний хуулийн хамгаалалтаас гадуур байлгах зорилгоор эрх чөлөөг нь хязгаарлаж, эсхүл байршлыг нь мэдээлэхээс татгалзана.

4. Энэхүү конвенцын зорилгоор “дайны гэмт хэрэг” гэж:

- a) Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн конвенцуудыг ноцтой зөрчсөн, тухайлбал Женевийн конвенцоор хамгаалагдсан этгээдүүд болон хөрөнгийн эсрэг хийсэн дараах үйлдлүүдийг ойлгоно:

- (i) бусдыг санаатай алах
- (ii) эрүү шүүлт тулгах, эсхүл хүнлэг бус хандах, үүнд биологийн туршилт орно;
- (iii) санаатайгаар хүний бие, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах;
- (iv) цэргийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй, хууль бусаар ямар нэгэн хэрэгцээ шаардлагагүйгээр эд хөрөнгийг их хэмжээгээр устгах болон олж авах;
- (v) дайны олзлогдогч буюу хамгаалалтад байгаа хүнийг дайсагнагч орны зэвсэгт хүчинд элсүүлэх;
- (vi) дайны олзлогдогч буюу хамгаалалтад байгаа хүнийг шударга, хууль ёсны шүүхээр шүүгдэх эрхийг нь санаатайгаар хасах;
- (vii) хууль бусаар албадан гаргах, эсхүл шилжүүлэх, эсхүл хууль бусаар хорих;
- (viii) хүнийг барьцаалах.

- b) Олон улсын эрх зүйн хүрээнд бий болсон олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хамаарах хууль тогтоомж, хэм хэмжээ ноцтой зөрчсөн дараах үйлдлүүд. Үүнд:


- (i). иргэдийн эсрэг, эсхүл дайнд шууд оролцоогүй иргэдийн эсрэг санаатайгаар халдах;
- (ii). цэргийн бус, иргэдийн хөрөнгийн эсрэг санаатайгаар халдах;




- (iii). зэвсэгт мөргөлдөөний олон улсын эрх зүйгээр иргэн, түүний хөрөнгийн адил хамгаалагдсан хүмүүнлэгийн тусламж, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн дагуу энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа алба хаагч, барилга байгууламж, материал, эд зүйл, тээврийн хэрэгслийн эсрэг санаатайгаар халдах;
- (iv). олон тооны амь үрэгдэх, иргэдэд, тэдгээрийн хөрөнгөд хохирол учрах, эсхүл байгаль орчинд өргөн хүрээнд, урт хугацаанд ноцтой хохирол учруулах замаар цэрэг-дайны хувьд давуу байдал бий болгон тооцоолон халдлага үйлдэх;
- (v). хамгаалалтгүй болон цэрэг-дайны халдлагын бус хот, тосгон, орон сууц буюу барилга байгууламжийн эсрэг халдах, эсхүл бөмбөгдөх;
- (vi). зэвсгээ хураалгаж, цаашид хамгаалалтын хэрэгсэлгүй болсон, эсхүл өөрийн шийдвэрээр бууж өгсөн цэргийг алах буюу шархдуулах;
- (vii). дайсны талтай гал зогсоох хэлэлцээ хийх эрх бүхий элчийн туг, эсрэг талын, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын далбаа, дүрэмт хувцас, цэргийн ялгах тэмдэг, түүнчлэн Женевийн конвенцуудаар тогтоосон ялгах тэмдгийг буруугаар ашигласнаас болж хүн амь насаа алдахад, эсхүл биед ноцтой гэмтэл учруулах;
- (viii). эзлэгч тал өөрийн иргэдийг шууд буюу шууд бусаар эзлэгдсэн нутаг дэвсгэрт нүүлгэн шилжүүлэх, эсхүл эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амыг бүхэлд нь буюу хэсгийг нь энэ нутаг дэвсгэрийн дотор, эсхүл эзлэгдсэн нутаг дэвсгэрээс гадагш албадан гаргах буюу шилжүүлэх;
- (ix). цэргийн бус барилга байгууламж буюу шашин, боловсрол, урлаг, шинжлэх ухаан, эсхүл хүмүүнлэгийн зориулалтай, түүх, соёлын дурсгалт газар, эмнэлэг болон өвчтөн, шархадсан хүмүүс цугларсан байршлын эсрэг санаатайгаар халдах;
- (x). эсрэг талын хүмүүсийн эрүүл мэнд, бие махбодод гэмтэл учруулах, тухайн хүнийг, эсхүл хүмүүсийг эмнэлгийн, шүдний эмчийн, эсхүл хэвтүүлж эмчлэх шаардлагад нийцээгүй, эрх ашигт нь нийцээгүй бөгөөд тухайн хүнийг үхэлд хүргэж болох, эрүүл мэндэд нь ноцтой аюул занал учруулахад хүргэх аливаа төрлийн эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийх;
- (xi). эсрэг талаас ирсэн иргэд, цэргийн алба хаагчдыг гэнэдүүлэн алах, эсхүл шархдуулах;
- (xii). юуг ч, хэнийг ч өршөөхгүй гэж зарлах;




- (xiii). цэрэг-дайнд шаардлагагүй эсрэг талын эд хөрөнгийг устгах буюу булаан авах;
- (xiv). эсрэг талын иргэдийн эрх болон үйлдлийг шүүх ажиллагаанд хамааралгүй, түдгэлзүүлсэн, эс зөвшөөрсөн гэж зарлах;
- (xv). эсрэг талын иргэдийг, дайн зарлагдахаас өмнө тухайн талд алба хааж байсан иргэдийг ч хамруулан, өөрийн орны эсрэг чиглэсэн дайны ажиллагаанд оролцохыг албадах;
- (xvi). эзлэн авснаас үл шалтгаалан хот буюу суурин газрыг тонон дээрэмдэх;
- (xvii). хор, хордуулах зэвсэг хэрэглэх;
- (xviii). амьсгал боогдуулах, хортой хий, ижил төрлийн шингэн, материал, тоног төхөөрөмж хэрэглэх;
- (xix). сумны толгой нь бүрэн бүрхэгдээгүй, эсхүл толгой нь нүхтэй, зүсэлттэй сум буюу хүний биед нэвтрээд хурдан тэлдэг сум хэрэглэх;
- (xx). хүний нэр төрд халдах, ялангуяа доромжлох буюу гутаан басамжлах байдлаар хүнтэй харьцах;
- (xxi). хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэхийг хүчээр тулгах, энэ зүйлийн 3 дахь хэсгийн (f)-д тодорхойлсны дагуу албадан жирэмслүүлэх, хүчээр засаж хөнгөлөх болон Женевийн конвенцуудыг ноцтой зөрчсөн бэлгийн хүчирхийллийн аливаа бусад төрөл;
- (xxii). энгийн хүн амаар, эсхүл хамгаалалт эдлэх бусад хүнээр халхавч хийж тодорхой суурин, цэг, бүс нутаг буюу зэвсэгт хүчнийхээ бие бүрэлдэхүүнийг эсрэг талын цэргийн үйл ажиллагаанаас хамгаалах зорилгоор ашиглах;
- (xxiii). Женевийн конвенцуудын ялгах тэмдгийг олон улсын эрх зүйн дагуу хэрэглэж байгаа барилга байгууламж, материал, эмнэлгийн нэгж, тээврийн хэрэгсэл, хүмүүс рүү санаатайгаар халдан довтлох;
- (xxiv). энгийн хүн амыг санаатайгаар өлсгөлөнд нэрвэгдүүлэх аргыг дайнд хэрэглэх, тухайлбал: Женевийн конвенцуудын дагуу энгийн хүн амд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд санаатайгаар саад учруулах, амь зуухад шаардлагатай зүйлээр гачигдуулах;
- (xxv). арван таван нас хүрээгүй хүүхдийг үндэсний зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд татан элсүүлэх, эсхүл тэдгээрийг баилдааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах замаар ашиглах зэрэг орно.



- с) Олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөний хувьд, зэвсгээ хураалгасан, мөн өвдсөн, шарх авсан, баривчлагдсан, эсхүл бусад шалтгааны улмаас байлдах боломжгүй болсон цэргийн алба хаагч зэрэг зэвсэгт мөргөлдөөнд идэвхтэй оролцоогүй этгээдийн эсрэг Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн дөрвөн конвенцын нийтлэг 3 дугаар зүйлийг ноцтойгоор зөрчсөн дараах үйлдлийг “дайны гэмт хэрэгт” тооцно, тухайлбал:
- (i) амь нас болон хувь хүний эсрэг чиглэсэн хүчирхийлэл, тухайлбал, бүх төрлийн аллага, эрхтнээс нь хагацуулах, харгис хэрцгий харьцах болон эрүү шүүлт тулгах;
 - (ii) хүний нэр төрд халдах, тухайлбал гутаан доромжлох болон зүй бус байдлаар харьцах;
 - (iii) хүнийг барьцаалах;
 - (iv) зайлшгүй байх ёстой гэж нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шүүн таслах ажиллагааны баталгааг хангах зорилгоор тогтмол ажиллагаатай байгуулагдсан шүүхийн бус шийдвэрээр ял оноож, түүнийг гүйцэтгэх;
- д) 4 дэх хэсгийн (с) дэд хэсэг нь олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөнд үйлчлэх тул бослого, тусгаарлагдмал ба тохиолдлын байдлаар гарах хүчирхийлэл, түүнтэй ижил төрлийн үйлдэл зэрэг дотоодын үймээн самуун, мөргөлдөөнтэй холбоотой нөхцөл байдалд хамаарахгүй;
- е) олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөний үед дагаж мөрддөг эрх зүйн хэм хэмжээ, заншлыг ноцтойгоор зөрчсөн дараах үйлдлийг олон улсын эрх зүйн хүрээнд “дайны гэмт хэрэгт” гэж тооцно, тухайлбал:
- (i) энгийн хүн ам, эсхүл дайны ажиллагаанд шууд оролцоогүй энгийн иргэн рүү санаатайгаар халдан довтлох;
 - (ii) олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн Женевийн конвенцуудын дагуу тогтоосон ялгах тэмдэг бүхий барилга байгууламж, материал, эмнэлэг, тээврийн хэрэгсэл, алба хаагчид рүү санаатайгаар халдан довтлох;
 - (iii) зэвсэгт мөргөлдөөний тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу энгийн иргэд, иргэний зориулалт бүхий объектын адил хамгаалагдаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн дагуу хүмүүнлэгийн тусламж үзүүлж, эсхүл энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа алба хаагч, байгууламж, материал, бүтэц, эсхүл тээврийн хэрэгсэл рүү санаатайгаар халдан довтлох;



- (iv) цэргийн зориулалтаар ашиглагдаагүй шашин, боловсрол, урлаг, шинжлэх ухаан, эсхүл хүмүүнлэгийн тусламжийн барилга байгууламж, түүхэн дурсгалт газар, эмнэлэг болон өвдсөн, шархадсан иргэдийг цуглуулсан байршил руу санаатайгаар халдан довтлох;
 - (v) довтолж авсан хот, эсхүл суурин газрыг тонон дээрэмдэх;
 - (vi) Женевийн дөрвөн конвенцын нийтлэг 3 дугаар зүйлийг ноцтойгоор зөрчсөн хүчиндэх, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхэд албадан татан оролцуулах, энэ зүйлийн 3 дах хэсгийн (f)-д тодорхойлсны дагуу албадан жирэмслүүлэх, албадан хөнгөлөх болон бэлгийн хүчирхийллийн бусад төрөл;
 - (vii) арван таван нас хүрээгүй хүүхдийг зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, эсхүл зэвсэгт бүлэглэлд татан оруулах, эсхүл элсүүлэх, тэднийг мөргөлдөөнд идэвхтэй оролцуулах замаар ашиглах;
 - (viii) аюулгүй байдлыг хангах, эсхүл байлдааны зайлшгүй шаардлага үүсэхээс бусад тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд холбоотой аль нэг шалтгаанаар энгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах;
 - (ix) эсрэг талын байлдагчийг гэнэдүүлэн алах, эсхүл шархдуулах;
 - (x) өршөөл үзүүлэхгүй гэж зарлах;
 - (xi) эрхшээлдээ байлгаж байгаа мөргөлдөөнд оролцогч эсрэг талын хүний бие махбодод гэмтэл учруулах, түүн дээр эмнэлгийн, эсхүл шинжлэх ухааны болон бусад төрлийн туршилт хийх. Ингэхдээ эдгээр туршилт нь эрүүл мэндийн, шүд эмчлэх, эсхүл эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх зэрэг аль нэг шалтгаанаар хийгдээгүй, тухайн хүний ашиг сонирхолд нийцээгүй ба түүний үхэлд хүргэж, эсхүл эрүүл мэндийг нь ноцтой хохироосон байна;
 - (xii) зэвсэгт мөргөлдөөний үеэр зайлшгүй үүсэх шаардлагаас бусад нөхцөлд дайтаж байгаа эсрэг талын өмч хөрөнгийг устгах, эсхүл булаан авах;
- f) 4 дэх хэсгийн (e) дэд хэсэг нь олон улсын бус чанартай зэвсэгт мөргөлдөөнд үйлчлэх тул бослого, тусгаарлагдмал болон тохиолдлын байдлаар гарах хүчирхийлэл, түүнтэй ижил төрлийн үйлдэл зэрэг дотоодын үймээн самуун, мөргөлдөөнтэй холбоотой нөхцөл байдалд хамаарахгүй. Энэ дэд хэсэг нь аль нэг улсын нутаг дэвсгэр дээр түүний төрийн эрх баригчид болон зохион байгуулалттай зэвсэгт бүлэглэл хооронд, эсхүл ийм зэвсэгт бүлэглэл хооронд удаан үргэлжилсэн мөргөлдөөнд хамаарна.



5. 4 дэх хэсгийн (с) болон (е) дэд хэсэг аль нэг Засгийн газрын улс дотроо хууль ёс, хэв журмыг сахиулах, түүнийг шинээр тогтоох, эсхүл хууль ёсны бүх аргаар улсынхаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах талаар хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
6. Энэхүү конвенцын зорилтын хүрээнд энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг, улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой, эсхүл улс төрийн сэдлээр үйлдсэн гэмт хэрэг гэж авч үзэхгүй.

6 дугаар зүйл. Энэхүү конвенцын нэмэлт хэрэглээ

2 дугаар зүйлд харшлахгүйгээр оролцогч улсууд хэн нэгний хүсэлтийн дагуу дараах шинж тэмдгийг бүрдүүлсэн үйлдэлд энэхүү конвенцыг хэрэглэхийг зөвшөөрч болно. Үүнд:

- а) тухайн үйлдэл нь олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, эзлэн түрэмгийлэл хийх, эрүүдэн шүүх, хүчээр алга болгох гэмт хэрэг байх;
- б) тухайн үйлдэл нь хүсэлт гаргасан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, эзлэн түрэмгийлэл хийх, эрүүдэн шүүх, хүчээр алга болгох гэмт хэрэг байх;
- с) тухайн үйлдлийг үйлдсэн тохиолдолд хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгөх боломжтой байх зэрэг хамаарна.

7 дугаар зүйл. Гэмт хэрэгт тооцох

1. Энэхүү конвенцын 2 дугаар зүйлд заасны дагуу аль нэг оролцогч улс аль нэг гэмт хэрэгт энэхүү конвенцын заалтыг хэрэглэж байгаа бол оролцогч бусад улс тухайн гэмт хэргийг дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу гэмт хэрэгт гэж тооцох шаардлагатай арга хэмжээг авна.
2. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийн хувьд түүний хүнд хөнгөний түвшнийг харгалзан зохих ял, шийтгэл тогтооно.

8 дугаар зүйл. Гэмт хэргийн харьялал

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг болон 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдэл хийсний дагуу энэхүү конвенцод хамааруулах аливаа гэмт хэргийн



харьяаллыг тогтооход шаардлагатай арга хэмжээг дараах тохиолдолд авна.
Үүнд:

- a) гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэр дээр, эсхүл тухайн улсад бүртгэгдсэн хөлөг онгоц дээр, эсхүл агаарын хөлөг дотор үйлдэгдэх;
 - b) гэмт хэргийн сэжигтэн тухайн улсын харьяат байх зэрэг орно.
2. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү конвенцод хамаарах, түүнчлэн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдэл хийсний дагуу энэхүү конвенцод хамааруулах аливаа гэмт хэргийн харьяаллыг тогтооход шаардлагатай арга хэмжээг дараах тохиолдолд авч болно. Үүнд:
- a) гэмт хэргийн сэжигтэн харьяалалгүй бөгөөд тухайн улсын нутаг дэвсгэрт гол төлөв оршин суудаг байх;
 - b) гэмт хэргийн хохирогч тухайн улсын харьяат байх зэрэг болно.
3. Оролцогч улс бүр гэмт хэргийн сэжигтэн түүний харьяа нутаг дэвсгэрт байгаа бөгөөд түүнийг энэ зүйлийн 1, 2 дугаар хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч байгаа аль нэг улсад, эсхүл тухайн сэжигтнийг эрх бүхий олон улсын эрүүгийн шүүх, эсхүл шүүх хуралдаанд хүлээлгэн өгөөгүй байгаа тохиолдолд гэмт хэргийн харьяаллыг тогтоох талаар дээрхтэй ижил төстэй арга хэмжээ авна.
4. Энэхүү конвенц нь аль нэг улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэсэн байхыг үгүйсгэхгүй.

9 дүгээр зүйл. Харьяат

Энэхүү конвенцын зорилгын хүрээнд оролцогч улс бүр “харьяат” гэсэн нэр томъёоны талаар дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн гаргасан тодорхойлолтыг эх хадгалагчид хэдийд ч бичгээр хүргүүлж болно.

10 дугаар зүйл. Хамтын ажиллагааны үндсэн зарчим

Оролцогч улс энэхүү конвенцын дагуу хамтран ажиллах талаар гаргасан хүсэлтийг дотоодын хууль тогтоомжийнхоо хүрээнд биелүүлнэ.

11 дүгээр зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

Энэхүү конвенцын зорилтын хүрээнд 2-р зүйлд заасны дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хувьд олон улсын эрх зүйн хэм хэмжээнд харшлах хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй.



12 дугаар зүйл. Гомдол гаргах эрх

1. Оролцогч улс бүр 2 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг гарсан, эсхүл гарч байгаа талаар мэдээлсэн аливаа этгээдийн эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхийг хангах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
2. Оролцогч улсууд хүлээн авсан аливаа гомдлыг дотоодын хууль тогтоомжийн дагуу, шаардлагатай бол холбогдох дотоодын бодлогын хүрээнд хугацаа алдалгүйгээр үнэн зөвөөр шалгах үүрэг хүлээнэ.

13 дугаар зүйл. Урьдчилсан арга хэмжээ

1. 2 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч аль нэг улс өөрт байгаа мэдээллийг шалгаад, үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тухайн сэжигтнийг цагдан хорих, эсхүл түүнийг байлцуулах талаар хуулийн дагуу өөр арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэх, шилжүүлэн өгөх, эсхүл хүлээлгэн өгөх ажиллагаа эхлүүлэхэд шаардагдах хугацаанд цагдан хорьж, хуулийн дагуу өөр арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.
2. Дээрх арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа оролцогч улс үйл баримтыг нэн даруй урьдчилсан байдлаар шалгана.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цагдан хоригдож байгаа аливаа этгээд харьяалагдах улсынхаа хамгийн ойр байгаа төлөөлөгчтэй, хэрэв харьяалалгүй бол оршин сууж заншсан улсынхаа төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтооход түүнд туслалцаа үзүүлнэ.
4. Энэ зүйлийн заалтын дагуу цагдан хорих арга хэмжээ авсан бол тухайн оролцогч улс нь уг этгээдийг цагдан хорьсон тухай болон цагдан хорих болсон үндэслэлээ 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан арга хэмжээ авсан оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу урьдчилсан байдлаар шалгалт хийж байгаа оролцогч улс өөрийн дүгнэлтээ холбогдох оролцогч бусад улсад шуурхай танилцуулж, мөн уг хэргийн тухайд харьяаллаа тогтоох эсэх байр сууриа мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл. Aut dedere, aut iudicare зарчим

1. 2 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийг үйлдсэн байж болзошгүй этгээд харьяалагдах нутаг дэвсгэрт нь байгаа гэж




- тогтоогдсон тохиолдолд тухайн оролцогч улс 8 дугаар зүйлд дурдсан нөхцөл байдал үүссэн бөгөөд тухайн этгээдийг өөр улс руу, эсхүл эрх бүхий олон улсын эрүүгийн шүүх, шүүх хуралдааны мэдэлд шилжүүлэн өгөөгүй бол хэргийг хянан шийдвэрлэж эхлэх үүднээс тухайн асуудлыг өөрийн харьяа эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.
2. Эрх бүхий эдгээр байгууллага нь тухайн оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хүнд гэмт хэрэг хянаж байгаатай адил журмаар шийдвэр гаргана. 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан тохиолдолд хэргийг хянан шийдвэрлэх болон ял оногдуулахад шаардагдах нотлох баримтын стандарт нь 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан тохиолдолд ашиглагддаг стандартаас аль ч үед зөөлөн байж болохгүй.
 3. Аль нэг этгээдийн эсрэг энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн бол тухайн этгээд уг ажиллагааны бүх шатанд хэргээ шударгаар хянан хэлэлцүүлэх баталгаагаар хангагдана.

15 дугаар зүйл. Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага

1. 2 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенц үйлчлэх гэмт хэрэг үйлдэхэд оролцсон хуулийн этгээдэд хариуцлага тооцох талаар оролцогч улс өөрийн эрх зүйн зарчимд нийцүүлэн шаардлагатай арга хэмжээ тогтооно.
2. Тухайн оролцогч улсын эрх зүйн зарчмын дагуу хуулийн этгээдэд эрүүгийн, иргэний, эсхүл захиргааны хариуцлага ноогдуулж болно.
3. Хуулийн этгээдэд ноогдуулах ийм хариуцлага гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд ноогдуулах эрүүгийн хариуцлагатай харшлахгүй байна.
4. Оролцогч улс бүр энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээсэн хуулийн этгээдэд мөнгөн торгуулийг хамруулан үр дүнтэй, үйлдсэн гэмт хэрэгт тохирсон, мөн бусдад сургамж болсон эрүүгийн, эсхүл эрүүгийн бус шийтгэл ноогдуулж байх нөхцөлийг бүрдүүлнэ.


16 дугаар зүйл. Хувийн мэдээлэл ашиглах болон хамгаалах

1. Оролцогч улсууд нэг оролцогч улсаас нөгөөд дамжуулах хувийн мэдээлэл зөвхөн түүнийг дамжуулах болсон зорилгод ашиглаж байх нөхцөлийг бүрдүүлнэ. Хувийн мэдээллийг зүй бусаар ашиглахыг хориглоно. Мэдээллийг анх дамжуулсан оролцогч улсаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр тухайн мэдээллийг аливаа гуравдагч улс, эсхүл олон улсын байгууллагад шилжүүлэхийг хориглоно. Хувийн мэдээлэл дамжуулж байгаа



оролцогч улс уг мэдээллийг цааш дамжуулах бол мэдээлэл хүссэн тухайн оролцогч улсад дагаж мөрдөх зарим болзол тавьж болно.


2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хувийн мэдээлэл өгөхдөө, түүнийг хэрхэн ашиглах талаар тусгай болзол тавьсан бол мэдээлэл хүссэн оролцогч улс нь хүсэлт хүлээн авсан оролцогч улсын шаардлагаар тухайн хувийн мэдээллийг хэрхэн ашигласан тухайгаа танилцуулна.
3. Мэдээлэл дамжуулсны дараа хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн тохиолдолд нэмэлт болзол тавих шаардлага нөхцөл байдал үүслээ гэж үзвэл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын эрх бүхий төв байгууллага хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаар хүсэлт гаргасан нөгөө оролцогч улсын эрх бүхий төв байгууллагатай зөвлөлдөнө.
4. Оролцогч улс үнэн зөв хувийн мэдээллийг өөр хоорондоо дамжуулна. Хэрэв буруу хувийн мэдээлэл дамжуулсан, эсхүл хүсэлт хүлээн авсан, хүсэлт гаргасан оролцогч улсын аль нэг нь хувийн мэдээлэл дамжуулах ёсгүй байсан гэж үзвэл энэ талаар холбогдох оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 8 болон 9 дэх хэсэгт заасны дагуу шаардагдахаас бусад тохиолдолд холбогдох оролцогч улс тухайн хувийн мэдээллийг цаг алдалгүйгээр засаж залруулж, эсхүл устгана.
5. Холбогдох этгээд хүсэлт гарган өөртэй нь холбоотой хувийн мэдээлэл дамжуулсан тухай болон уг мэдээллийг хэрхэн ашиглах зорилгын талаар мэдээлэл авч болно. Гэхдээ ийм мэдээллийг гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шалгах явцад саад учруулахгүй байх үүднээс нууцалж болно.
6. Энэ зүйлийн 8 болон 9 дэх хэсэгт дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдахаас бусад үед хүсэлт гаргасан оролцогч улс зорилт хангагдмагц хүлээн авсан тухайн хувийн мэдээллийг устгаж, эсхүл эзэн биегүй болгоно.
7. Хүсэлт гаргасан оролцогч улс нь хүлээн авсан хувийн мэдээллийг санамсаргүйгээр бусдад алдах, санамсаргүйгээр, эсхүл хууль бусаар устгаж, өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр задруулах, зөвшөөрөлгүйгээр нэвтрэх болон зөвшөөрөлгүйгээр бусад хэлбэрээр ашиглуулахаас хамгаалах арга хэмжээг зохих ёсоор авна.
8. Энэхүү конвенцын зорилгын хүрээнд оролцогч улсууд хэн нэгний талаар мэдээлэл дамжуулагдсан бол тухайн этгээд мэдээлэл дамжуулсан болон мэдээлэл хүлээн авсан улсад хандан тухайн хувийн мэдээлэлтэйгээ танилцах, түүнийг засах, эсхүл устгуулах эрхтэй байхыг хангана. Энэ эрхийг хэрэгжүүлэх нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зорилготой харшилж, эсхүл бусдын эрх, эрх чөлөөнд нөлөөлөх бол эрх хэрэгжүүлэхийг хязгаарлаж болно.



9. Оролцогч улсууд энэ зүйлд дурдсан аль нэг үүрэг зөрчигдөх тохиолдолд холбогдох этгээд эрх зүйн хамгаалалтын үр дүнтэй арга ашиглах эрхтэй байхыг хангана.
10. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн мэдээлэл дамжуулахыг хориглосон, эсхүл мэдээлэл дамжуулснаар холбогдох этгээдийн хууль ёсны эрх ашиг хөндөгдөж байгаа бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс хувийн мэдээлэл дамжуулах үүрэг хүлээхгүй.

17 дугаар зүйл. Мэдээлэл шууд солилцох


1. Аль нэг оролцогч улс оролцогч нөгөө улсын хувьд гэмт хэргийг мөрдөх ажиллагаа болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, эсхүл амжилттай хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлж магадгүй, эсхүл энэхүү конвенцын дагуу оролцогч нөгөө тал хүсэлт гаргаж магадгүй гэж үзсэн тохиолдолд дотоодын хууль тогтоомжид харшлахгүйгээр энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг урьдчилан хүсэлт авалгүйгээр дамжуулж болно. Эрх зүйн өөр баримт бичигт тусгагдсан илүү таатай нөхцөлийг хөндөхгүйгээр оролцогч улсууд тус тусын эрх бүхий байгууллагаар дамжуулан мэдээллийг шууд солилцоно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хийгдэх мэдээлэл дамжуулах ажиллагаа нь тухайн мэдээлэл өгч байгаа оролцогч улсад явагдаж байгаа мөрдөн шалгах болон эрүүгийн ажиллагаанд харшлах ёсгүй.
3. Мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага нь мэдээлэл өгсөн оролцогч улсаас тавьсан мэдээллийг нууцлалыг түр хугацаагаар ч боловч хадгалах, эсхүл хязгаарлагдсан хүрээнд ашиглах талаар гаргасан хүсэлтийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.
4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийг үл харгалзан мэдээлэл хүлээн авсан оролцогч улс гэмт хэрэгт яллагдагчийг цагаатгах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр хүлээн авсан тухайн мэдээллийг ил болгож болно. Энэ тохиолдолд мэдээлэл хүлээн авсан оролцогч улс мэдээллийг ил болгох тухайгаа мэдээлэл өгсөн оролцогч улсад урьдчилан мэдэгдэж, шаардлагатай бол түүнтэй зөвлөлдөнө. Урьдчилан мэдэгдэх боломжгүй онцгой тохиолдолд мэдээлэл хүлээн авсан оролцогч улс мэдээллийг ил болгосон тухайгаа цаг алдахгүйгээр мэдээлэл өгсөн оролцогч улсад мэдэгдэнэ.



5. Мэдээлэл өгсөн улсын хүсэлт гаргасан бол тухайн дамжуулсан мэдээллийг эрх зүйн туслалцаа үзүүлэхийг зөвшөөрөхөөс өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт болгон ашиглахыг хориглоно.

18 дугаар зүйл. Зардал

1. Энэхүү конвенцод өөрөөр заагаагүй ба холбогдох оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс энэхүү конвенцын дагуу гаргасан хүсэлтийг биелүүлэх энгийн зардлыг хариуцна. Хэрэв хүсэлтийг биелүүлэхэд их хэмжээний, эсхүл нэмэлт зардал шаардагдаж, эсхүл шаардагдахаар байгаа бол холбогдох оролцогч улс өөр хоорондоо хүсэлтийг биелүүлэх нөхцөл, болзлыг, мөн зардлыг хэрхэн зохицуулах арга замыг тодорхойлох талаар зөвлөлдөнө.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс зардлыг бусдаар бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нөхөн төлүүлэхээс татгалзаагүй тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс дараах зардлыг төлж, эсхүл нөхөн олгоно. Үүнд:
 - a) хүсэлт хүлээн авсан оролцогч улсын нутаг дэвсгэр дээр шинжээчдийг оролцуулахад гарсан зардал;
 - b) видео болон утсан холбоо суурилуулах, ашиглахтай холбоотой зардал;
 - c) хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас томилсон орчуулагчийн цалин хөлс;
 - d) гэрчид олгох тэтгэмж, мөн түүнийг хүсэлт хүлээн авсан оролцогч улсын нутаг дэвсгэрт тээвэрлэх болон байлгахтай холбоотой зардал зэрэг багтана.
3. Саатуулагдсан этгээдийг 36 дугаар зүйлийн дагуу шилжүүлэн авч байгаа бол хүсэлт гаргасан улс тухайн этгээдийг тээвэрлэхтэй холбоотой гарах зардлыг хариуцна.
4. Аль нэг этгээдийг шилжүүлэн авах бол хүсэлт гаргасан улс тухайн этгээдийг тээвэрлэхтэй холбоотой гарах зардлыг хариуцна.
5. Ялын шийдвэрийг өөр оролцогч улсад гүйцэтгэх бол тухайн ял гүйцэтгэх оролцогч улс ялтанг тээвэрлэхтэй холбоотой гарах зардлыг хариуцна.



19 дүгээр зүйл. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх болон шилжүүлэн өгөхтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү конвенцын зорилгод нийцүүлэн:

- a) зарим үед өмчлөх эрхийг алдах тохиолдлыг оролцуулан "албадан хураах" гэж шүүх болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг бүр мөсөн авахыг;
- b) "царцаах" буюу "түр хугацаагаар хураан авах" гэдэг нь шүүх болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр эд хөрөнгийг шилжүүлэх, хөрвүүлэх, захиран зарцуулах эрхийг түр хугацаагаар хориглох, эсхүл тухайн эд хөрөнгийг бусдын мэдэлд, эсхүл хяналтад түр хугацаагаар авахыг;
- c) "гэмт хэргийн орлого" гэж энэхүү конвенц үйлчлэх гэмт хэрэг үйлдсэний улмаас шууд болон шууд бусаар бий болсон, эсхүл олж авсан аливаа эд хөрөнгийг;
- d) "эд хөрөнгө" гэж хувийн болон нийтийн, хөдлөх ба үл хөдлөх, биет болон биет бус өмч болон өмчлөх эрхийг нотолсон эрх зүйн баримт бичгийг тус тус ойлгоно.



**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭРХ БҮХИЙ ТӨВ БАЙГУУЛЛАГА БА
ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

20 дугаар зүйл. Эрх бүхий төв байгууллага

1. Аливаа оролцогч улс бүр эрх бүхий нэг, эсхүл түүнээс дээш тооны төв байгууллагыг томилно. Эрх бүхий төв байгууллага нь энэхүү конвенцын заалтын дагуу хамтын ажиллагааны талаарх хүсэлт болон мэдээлэл илгээж, хүлээн авах үүрэг хүлээх бөгөөд холбогдох байгууллагууд тухайн хүсэлтийг цаг хугацаанд нь зохих ёсоор гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
2. Энэхүү конвенцын дагуу хамтын ажиллагааг хэрэгжүүлэх тусдаа тогтолцоо бүхий тусгай бүс нутаг, эсхүл газар нутагтай бол тухайн оролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан чиг үүргийг уг бүс нутаг, эсхүл газар нутагт гүйцэтгэх тусгайлсан эрх бүхий төв байгууллагыг томилж болно.
3. Энэхүү конвенцын зарим заалтын дагуу хүсэлт, мэдээлэл илгээж, хүлээн авах үүргийг тусгайлсан эрх бүхий төв байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн оролцогч улс энэхүү конвенцын холбогдох заалтыг биелүүлэхэд зориулж энэ зүйлийн 1 дэх хэсгийн чиг үүргийг гүйцэтгэх тусгайлсан эрх бүхий өөр төв байгууллагыг шинээр томилж болно.
4. Оролцогч нэг болон түүнээс дээш улсын санаачилгаар эрх бүхий төв байгууллагууд энэхүү конвенцыг хэрэглэх асуудлаар хоорондоо зөвлөлдөж болно.
5. Энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл түүнийг соёрхон батлах, зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар хүлээлгэн өгөхдөө улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий нэг, эсхүл түүнээс дээш тооны төв байгууллагын томилсон талаар эх хадгалагчид хандан зарлан мэдэгдэнэ. Улс бүр ийм мэдэгдлийн агуулгыг өмнө зарлаж байсантайгаа ижил хэлбэрээр цаашдаа өөрчилж байж болно.

21 дүгээр зүйл. Харилцах суваг ба холбоо барих нэг харилцагчтай байх

1. Энэхүү конвенцын дагуу гаргасан хүсэлт болон түүнтэй холбоотой аливаа мэдээллийг оролцогч улсын эрх бүхий төв байгууллага хооронд дамжуулна.
2. Энэхүү конвенцод гарын үсэг зурах, эсхүл түүнийг соёрхон батлах, зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар хүлээлгэн өгөхдөө, эсхүл үүний дараа тухайн улс түүнд илгээх хүсэлтийг дипломат шугамаар болон/эсхүл боломжтой тохиолдолд



Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамжуулж байхыг эх хадгалагчид хандан мэдэгдэж болно.

3. Энэхүү конвенцын дагуу гаргасан тухайн хүсэлтийг биелүүлэхтэй холбоотой харилцааг хөнгөвчлөх үүднээс оролцогч улс тус бүрдээ 20 дугаар зүйлийн 1-ээс 4 хүртэлх хэсгийг хөндөхгүйгээр эрх бүхий төв байгууллага дотроо холбоо барих нэг харилцагчийг томилно. Эдгээр харилцагч нар тухайн хүсэлтийг биелүүлэхтэй холбогдсон практик асуудлаар өөр хоорондоо харилцаж болно.
4. Оролцогч улс бүр томилогдсон харилцагчийнхаа талаарх мэдээллийг 85 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу өгнө.
5. Хэрэв оролцогч улсууд харилцан зөвшөөрч, мөн мэдээллийн нууц хадгалалт, түүний үнэн зөв байх шаардлага хангасан тохиолдолд энэхүү конвенцыг үндэслэн хүсэлт, мэдээлэл дамжуулж, харилцахдаа баталгаатай цахим хэрэгслийг ашиглаж болно. Ямар ч тохиолдолд холбогдох оролцогч улс баримт бичгийн эх хувь, эсхүл түүний баталгаат хуулбарыг хүсэлтийн дагуу хэдийд ч хүлээлгэн өгнө.

22 дугаар зүйл. Хүлээн зөвшөөрөгдөх хэл

1. Хүсэлт хүлээн авах оролцогч улсын хүлээн зөвшөөрөх хэлээр тухайн хүсэлтийг үйлдэнэ.
2. Оролцогч улс бүр өөрийн хүлээн зөвшөөрөх нэг, эсхүл түүнээс дээш тооны хэлний талаар оролцогч бусад улсын эрх бүхий төв байгууллага, эсхүл 85 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан нөхцөл хангагдсан бол түр зуурын нэмэлт дэмжлэг үзүүлэхээр томилогдсон улсад тус тус мэдэгдэнэ.



ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ

23 дугаар зүйл. Гуравдугаар бүлгийн хамрах хүрээ

1. Энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгт холбогдуулан явуулж буй мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч улсууд өргөн хүрээнд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлнэ.
2. Энэхүү конвенцын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлт гаргасан оролцогч улсад хуулийн этгээдэд гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр явуулж буй мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүсэлт хүлээн авсан оролцогч улс хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрийн дагуу бүх боломжит байдлаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлнэ.

24 дүгээр зүйл. Хүсэлтийн зорилго

Энэхүү конвенцын зүйл, заалтын дагуу дараах байдлаар эрх зүйн туслалцаа үзүүлнэ. Үүнд:

- (a) хувь хүнээс нотлох баримт болон мэдүүлэг авах, үүнд хүсэлт хүлээн авсан оролцогч улсын хууль тогтоомжоор зөвшөөрсөн бол цахим хуралдаан явуулах;
- (b) объект болон тухайн орчинд үзлэг хийх;
- (c) мэдээлэл, эд мөрийн баримт, шинжээчийн дүгнэлт гаргах;
- (d) нэгжлэг хийх, битүүмжлэх, хураан авах ажиллагаа явуулах;
- (e) шүүхийн баримт бичиг хүргүүлэх;
- (f) баримт бичгийн эх хувь, эсхүл хуулбарыг гаргуулан авах, түүнчлэн шаардлагатай тохиолдолд баримт бичиг, хуулга, цахим мэдээлэл, албаны болон банк, санхүү, бизнесийн мэдээллийг баталгаажуулан гаргуулан авах;
- (g) хүсэлт гаргасан оролцогч улсад хүнийг сайн дураар ирүүлэх, саатуулагдсан этгээдийг түр хугацаагаар шилжүүлэн авахад дэмжлэг үзүүлэх;
- (h) мөрдөн шалгах тусгай арга хэмжээ явуулах;
- (i) хил дамнасан ажиглалт явуулах;
- (j) мөрдөн шалгах хамтарсан ажлын хэсэг байгуулах;
- (k) хохирогч, гэрчийг болон тэдгээрийн эрхийг зохих байдлаар хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авах;
- (l) хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бусад байдлаар туслалцаа үзүүлэх.



25 дугаар зүйл. Хүсэлт болон хавсаргах баримт бичиг


1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг бичгээр үйлдэж, хүсэлтийг хүлээн авсан оролцогч улсаас үнэн зөвийг тогтоохтой холбоотой шаардлагуудыг хангасан байна.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хүсэлт нь дараах агуулгатай, эсхүл дараах зүйлсийг хавсаргасан байна. Үүнд:
 - а) Хүсэлт гаргасан байгууллагын тухай мэдээлэл;
 - б) Хүсэлттэй холбоотой мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, хэргийн утга болон мөрдөн шалгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагын нэр, чиг үүрэг;
 - в) Шүүхийн баримт бичиг хүргүүлэх, гардуулах хүсэлтээс бусад тохиолдолд холбогдох нөхцөл байдлын тухай хураангуй мэдээлэл;
 - г) Дотоодын холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн зүйл, заалт болон гэмт этгээдэд оногдуулсан, эсхүл оногдуулах ял шийтгэлийн тухай мэдээлэл;
 - д) Хүсэж буй эрх зүйн туслалцааны тухай дэлгэрэнгүй тайлбар болон хүсэлт гаргасан оролцогч улсын дагаж мөрдөхийг хүсэж буй тодорхой дарааллын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
 - е) Тодорхой болсон тохиолдолд холбогдогч этгээдийн биеийн байцаалт, байршил болон иргэний харьяаллын тухай мэдээлэл;
 - ж) Нотлох баримт, мэдээлэл гаргуулан авах, ажиллагаа явуулах шаардлагатай бол мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямар ач холбогдолтой талаар мэдээлэл;
 - з) Шаардлагатай тохиолдолд ямар хугацаанд туслалцаа үзүүлэх, шалтгааныг нь тайлбарлах;
 - и) Шаардлагатай тохиолдолд гэрчид мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг нь хангуулахтай холбоотой дотоодын хууль тогтоомжийн талаар тайлбар зэрэг орно.
3. Яаралтай тохиолдолд буюу хүсэлт гаргасан оролцогч улс, хүсэлт хүлээн авсан оролцогч улс харилцан тохиролцсон бол хүсэлтийг амаар илэрхийлж болох ба ингэхдээ 1болон 2 дэх хэсгийн дагуу даруй бичгээр үйлдэж, баталгаажуулна.

26 дугаар зүйл. Эрх зүйн туслалцааны хүсэлтийн нууцлал

Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэхтэй холбогдуулан шаардлагатай зүйлээс бусад нөхцөл байдал, агуулга, үр дүнг нууцална. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нууцлахтай холбоотой шаардлагыг хангах боломжгүй бол энэ талаар хүсэлт гаргасан оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ. Хүсэлт гаргасан оролцогч улс үүнийг үл харгалзан хүсэлтийг гүйцэтгүүлэх эсэхээ шийдвэрлэнэ.

27 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ

1. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь нотлох баримтыг хадгалан хамгаалах, тодорхой байдалд хэвээр нь хадгалах, эрсдэлд орж болзошгүй хууль ёсны эрх



ашгийг хамгаалах зорилгоор дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хүсэлт гаргасан оролцогч улсын хүсэлтийн дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлтэд дурдсан таслан сэргийлэх арга хэмжээг хэсэгчлэн, эсхүл холбогдох нөхцөлийн дагуу арга хэмжээ үргэлжлэх хугацаагаар хязгаарлаж болно.

28 дугаар зүйл. Нэмэлт мэдээлэл

Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь эрх зүйн туслалцааны хүсэлтээр авагдсан мэдээлэл шийдвэр гаргахад, эсхүл гүйцэтгэхэд хангалтгүй гэж үзвэл шаардлагатай нэмэлт мэдээллийг зохих боломжит хугацаанд багтаан ирүүлэхийг хүсэж болно.

29 дүгээр зүйл. Эрх зүйн туслалцааны хууль зүйн үндэслэл

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг үндэслэх нөхцөл заасан оролцогч улсад тухайн гэрээг байгуулаагүй өөр оролцогч улсаас хүсэлт хүлээн авсан бол конвенцод заасан гэмт хэрэгт холбогдуулан түүнийг эрх зүйн туслалцаа үзүүлэх хууль зүйн үндэслэл болгон хэрэглэж болно.

30 дугаар зүйл. Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах үндэслэл

1. 2 дахь хэсэгт заасан зарчмын дагуу дараах тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзана. Үүнд:
 - a. Хүнийг арьсны өнгө, хүйс, сэтгэц, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлага, шашин шүтлэг, үндэс угсаа, үндэсний гарал үүсэл, улс төрийн үзэл бодол, эсхүл нийгмийн тодорхой бүлэгт хамаарахтай нь холбогдуулан шалгах, хянан шийдвэрлэхийн тулд хүсэлт гаргасан, эсхүл хүсэлтийг гүйцэтгэснээр эдгээр шалтгааны улмаас тухайн хүний нөхцөл байдал дордох;
 - b. Хүсэлт гаргасан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид цаазаар авах ял оногдуулахаар хүсэлтэд заасан хэдий ч хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид заасан дараах шаардлагыг хангасан. Үүнд:
 - (i) Хүсэлт гаргасан оролцогч улс хангалттай баталгаа гаргасан, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын цаазаар авах ял оногдуулахгүй байх тухай нөхцөлийг хүлээн авч, шаардлагыг хангасан бол; эсхүл
 - (ii) Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд цаазаар авах ял ногдуулахаар шийдвэр гарч, хүсэлт гаргагч талаас хангалттай баталгаа гаргасан, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас тавьсан шаардлага нөхцөлийг хүлээн авч, цаазаар авах ялыг оногдуулахгүй бол;



- c. Хүсэлтэд хүсэлт хүлээн авсан оролцогч улсад ижил төстэй үйлдлээр гэмт хэрэгт шалгагдан эцэслэн шийдвэрлэгдсэн талаар нөхцөл байдал дурдсан;
 - d. Хүсэлт гаргасан оролцогч улс хүсэлтэд нэр дурдагдсан этгээдийг эрүүдэн шүүх, эсхүл харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжлох бусад аргаар шийтгэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг бүдүүлгээр зөрчих, хүний үндсэн эрхийг бусад байдлаар бүдүүлгээр зөрчих болно гэж хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор үзэх үндэслэлтэй;
 - e. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага нь өөрсдийн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхээр хянан шийдвэрлэсэн ижил төрлийн гэмт хэрэгт ирүүлсэн хүсэлтийг гүйцэтгэхийг хориглосон;
 - f. Хүсэлт нь энэхүү конвенцын зүйл, заалтад нийцээгүй;
 - g. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр түүний бүрэн эрх, аюулгүй байдал, нийтийн хэв журам болон бусад чухал ашиг сонирхолд хохирол учруулна гэж үзвэл;
 - h. Хүсэлтийг хүсэлт гаргасан оролцогч улсын түр шүүх, эсхүл трибуналын нэрийн өмнөөс гаргасан бол. Ингэхдээ хүсэлт гаргасан оролцогч улсын эрх бүхий байгууллагаас эрүүгийн хэргийн асуудлаарх шүүхийн захиргааны байгууллагын журмын дагуу эрх олгогдсон шүүхээс шийдвэр гарна гэсэн хангалттай баталгаа гаргасан бол болно;
 - i. Хүсэлтийг гүйцэтгэх зөвшөөрөл олгосноор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчих;
 - j. Хүсэлтэд нэр дурдагдсан этгээд тэнсэн харгалзах ял, эсхүл тодорхойгүй хугацаагаар хоригдох байдлаар бүх насаар хоригдох ял шийтгэл оногдох бодит эрсдэлтэй байна гэж үзэх хангалттай үндэслэл байх зэрэг хамаарна.
2. Оролцогч улсууд 1 дэх хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэхдээ хүний эрх, үндсэн эрх чөлөө, үүнд хүний амьд явах эрх, эрх чөлөө, аюулгүй байдалтай холбоотой олон улсын болон дотоодын зарчмуудыг харгалзан үзнэ.
3. Оролцогч улсууд хүсэлтэд заасан гэмт хэрэг нь татварын асуудал, эсхүл банкны нууцлалтай холбоотой гэх цор ганц үндэслэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болохгүй.
4. Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан бол шалтгааныг нь мэдэгдэнэ.
5. Энэ зүйлд заасны дагуу хүсэлтэд татгалзах хариу өгөхөөс өмнө, эсхүл 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу түүний гүйцэтгэлийг хойшлуулахаас өмнө хүсэлт хүлээн авсан оролцогч улс боломжтой тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улстай зөвшөөрөл олгоход шаардлагатай нөхцөлийг хангаснаар туслалцаа үзүүлэх талаар зөвлөлдөнө. Хүсэлт гаргасан оролцогч улс нөхцөлийг хүлээн зөвшөөрвөл тухайн нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ.



**31 дүгээр зүйл. Мэдээлэл, нотлох баримт дамжуулах,
ашиглахтай холбоотой хязгаарлалт**

1. Хүсэлт гаргасан оролцогч улс хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас зөвшөөрөл авахгүйгээр мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүлээн авсан мэдээлэл, нотлох баримтыг хүсэлтэд зааснаас бусад байдлаар дамжуулах, эсхүл ашиглаж болохгүй.
2. Энэ зүйл нь хүсэлт гаргасан оролцогч улсыг хэрэгт холбогдогч этгээдэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримтыг ажиллагааны үеэр танилцуулах явдлыг хязгаарлахгүй. Энэ тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс танилцуулахаас өмнө хүсэлт хүлээн авсан оролцогч улсад мэдэгдэх бөгөөд тухайн улсаас хүсэлт гаргасан бол хүсэлт хүлээн авсан оролцогч улстай зөвлөлдөнө. Урьдчилан мэдэгдэх боломжгүй, онцгой тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс танилцуулсан талаар нэн даруй хүсэлт хүлээн авсан оролцогч улсад мэдэгдэнэ.
3. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас шилжүүлэн өгсөн мэдээлэл, нотлох баримтыг ашиглахтай холбоотой тусгай нөхцөл заасан бол хүсэлт гаргасан оролцогч улс хүсэлт хүлээн авсан оролцогч улсын хүсэлтийн дагуу мэдээлэл, нотлох баримтыг ашигласан талаар мэдээлэл хүргүүлнэ.
4. Хүсэлт гаргасан оролцогч улс танилцуулсантай холбогдуулан хүсэлт хүлээн авсан оролцогч улсад тодорхой хэрэгт нэмэлт нөхцөл тусгах шаардлагатай нөхцөл байдал бий болсон бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлт гаргасан оролцогч улсын төв байгууллагатай нотлох баримт, мэдээллийг хамгаалах арга хэмжээ авах талаар зөвшилцөнө.

32 дугаар зүйл. Хүсэлтийг гүйцэтгэх

1. Хүсэлтийг хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу түүнтэй зөрчилдөхөөргүй хэмжээнд зохих дэс дарааллын дагуу гүйцэтгэнэ.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь хүсэлтийг түргэн шуурхай гүйцэтгэх бөгөөд хүсэлт гаргасан оролцогч улсаас хүсэлтэд тайлбарлан заасан хугацааг анхааралдаа авна. Хүсэлт гаргасан оролцогч улс туслалцаа үзүүлэх шаардлагагүй болсон талаар нэн даруй хүсэлт хүлээн авсан оролцогч улсад мэдэгдэнэ.
3. Хүсэлт гаргасан оролцогч улсын яаралтай хүсэлтэд хүсэлт хүлээн авсан оролцогч улс боломжит байдлаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэсэн огноо, газрыг тэмдэглэнэ. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд холбогдох албан тушаалтан, хамаарал бүхий этгээдүүд байлцаж болно.
4. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлтийг гүйцэтгэснээр одоо явагдаж буй мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулна гэж үзвэл хүсэлтийн гүйцэтгэлийг хойшлуулж болно. Боломжтой тохиолдолд хойшлуулах болсон шалтгаан, гүйцэтгэгдэх хугацаа, нөхцөлийн талаар хүсэлт гаргасан оролцогч улсад мэдэгдэнэ.




33 дугаар зүйл. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсад мэдүүлэг авах

1. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гэрч, шинжээчээс мэдүүлэг авна. Хүсэлт гаргасан оролцогч улс, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор гэрч, шинжээчид мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх эдэлдэг бол мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно.
2. Хүсэлт гаргасан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид мэдүүлэг өгөхөөс татгалзахаар заасан бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс энэ талаар хүсэлт гаргасан оролцогч улстай зөвшилцөнө.
3. Гэрч, шинжээч нь 1 дэх хэсэгт заасан мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдэлсэн тохиолдолд энэ үйлдлийнхээ төлөө хүсэлт гаргасан, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсад ял шийтгэл хүлээлгэхгүй.
4. Хувь хүнийг хамгаалах асуудлаар тохиролцсон аливаа арга хэмжээнд саад учруулахгүйгээр хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь сонсголын төгсгөлд хуралдааны огноо, газар, мэдүүлэг өгсөн хүний биеийн байцаалт, биеийн байдал, хүсэлт хүлээн авсан оролцогч улсын сонсголд оролцож буй бусад этгээдийн чиг үүрэг, сонсголын үед өргөсөн тангараг болон сонсгол явагдсан техникийн нөхцөлийг тусгасан тэмдэглэл үйлдэнэ. Энэ баримт бичгийг хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлт гаргасан оролцогч улсад шилжүүлэн өгнө.
5. Энэ зүйлд заасны дагуу гэрч, шинжээчид өөрсдийн нутаг дэвсгэрт мэдүүлэг өгөх, эсхүл үнэн зөв мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол оролцогч талууд дотоодын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар мэдүүлэг авсны нэгэн адил арга хэмжээ авна.

34 дүгээр зүйл. Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулах

1. Оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа этгээд өөр оролцогч улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч буюу шинжээчээр оролцох шаардлагатай болсон хэдий ч биеэр оролцох хүсэлгүй, эсхүл боломжгүй тохиолдолд энэ зүйлийн 2-7 дугаар хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулах хүсэлт гаргаж болно. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд энэ хэсгийг эд зүйл, хүн, эсхүл байршил таниулах зорилгоор цахим хэлбэрээр хуралдаан явуулахад хэрэглэж болно.
2. Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулснаар хүсэлтийг хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмуудтай харшлахгүй бөгөөд шүүх хуралдааныг цахимаар явуулах техникийн хэрэгсэл хангагдсан гэж үзсэн тохиолдолд хүсэлтийг зөвшөөрч хариу мэдэгдэнэ. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсад шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулахад техникийн хувьд боломжгүй тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хүсэлт гаргасан оролцогч улсаас шаардлагатай техник хэрэгслийг гаргуулна.
3. Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулах тухай хүсэлтэд энэхүү конвенцын 25 дугаар зүйлд зааснаас гадна нэмэлтээр хянан шийдвэрлэх ажиллагаа



явуулж буй шүүх байгууллагын нэр, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улс зөвшөөрсөн бол шүүх хуралдааныг явуулах эрх бүхий байгууллагын нэрийг оруулна.

4. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын шүүхийн байгууллага нь холбогдогч этгээдийг дотоодын хууль тогтоомжид заасны дагуу зарлан дуудах хуудсаар дуудан оролцуулна.
5. Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулах үед дараах дүрмийг баримтална. Үүнд:
 - a. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын шүүх байгууллага шаардлагатай тохиолдолд шүүх хуралдаанд орчуулагч байлцуулж, холбогдогч этгээдийн биеийн байцаалтыг баталгаажуулахтай холбоотой дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчмыг дагаж мөрдөнө. Шүүх хуралдааны үеэр дотоодын хууль тогтоомжид заасан үндсэн зарчмууд зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд энэ хуралдааныг тухайн зарчмуудын дагуу үргэлжлүүлэн явуулахад шаардлагатай арга хэмжээг нэн даруй авна;
 - b. Шаардлагатай тохиолдолд хүсэлт хүлээн авсан болон хүсэлт гаргасан оролцогч улсуудын эрх бүхий байгууллага мэдүүлэг өгөх этгээдийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой арга хэмжээ авах талаар тохиролцоно;
 - c. Шүүх хуралдааныг хүсэлт гаргасан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид заасны дагуу шүүх байгууллагын шууд удирдаж, эсхүл удирдлага дор явуулна;
 - d. Шаардлагатай гэж үзвэл хүсэлт гаргасан оролцогч улс, эсхүл мэдүүлэг өгөх этгээдийн хүсэлтээр хүсэлт хүлээн авсан оролцогч улс мэдүүлэг өгөх этгээдэд орчуулагчийн, эсхүл/болон өмгөөлөгчийн туслалцаа үзүүлнэ;
 - e. Мэдүүлэг өгөх этгээд хүсэлт гаргасан оролцогч улс, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид заасан мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхээ эдэлж болно.
6. Оролцогч улсууд энэ зүйлийг үндэслэн өөрсдийн үзэмжээр хэрэгт холбогдсон этгээд, эсхүл сэжиглэгдсэн этгээдийг өөрийнх нь зөвшөөрлийн дагуу цахим хэлбэрээр шүүх хуралдаанд оролцуулж болно. Энэ тохиолдолд цахим хэлбэрээр шүүх хуралдааныг зохион байгуулах шийдвэр, арга хэлбэрийг оролцогч улсууд өөрсдийн дотоодын хууль тогтоомж болон олон улсын холбогдох хэм хэмжээг үндэслэн харилцан тохиролцоно.
7. Энэ зүйл нь шүүх хуралдааныг цахим хэлбэрээр явуулахыг зөвшөөрсөн аливаа хэлэлцээр, тохиролцоотой харшлахгүй.




35 дугаар зүйл. Хүсэлт гаргасан оролцогч улсад хүн байлцуулах

1. Хүсэлт гаргасан оролцогч улс нь гэрч, эсхүл шинжээчийг шүүх байгууллагын өмнө биечлэн байцуулах шаардлагатай гэж үзвэл зарлан дуудах хүсэлтэд энэ талаар тусгана. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь гэрч, эсхүл шинжээчийг хүсэлт гаргасан оролцогч улсын нутаг дэвсгэрт очихыг урих бөгөөд гэрч, эсхүл шинжээчийн өгсөн хариуг хүсэлт гаргасан оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт, эсхүл зарлан дуудах хуудаст төлөгдөхөөр тооцоологдсон боломжит тэтгэмж, тээвэр болон амьжиргааны зардлыг тусгана.
3. Тодорхой хүсэлт гаргасан бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс гэрч, эсхүл шинжээчид урьдчилгаа олгож болно. Тухайн урьдчилгааг хүсэлт гаргасан оролцогч улсаас нөхөн олгоно.
4. Үйлчилгээ үзүүлэх зарлан дуудах хуудсыг биелүүлэхээс татгалзсан гэрч, эсхүл шинжээчид үүрэг хүлээсэн байснаас үл хамааран хариуцлага, эсхүл хязгаарлалт тогтоож болохгүй. Гэрч, эсхүл шинжээч өөрөө сайн дураар хүсэлт гаргасан оролцогч улсын нутаг дэвсгэрт нэвтэрч орсон тохиолдолд дахин дуудагдана.

36 дугаар зүйл. Саатуулагдсан этгээдийг түр хугацаагаар шилжүүлэх

1. Оролцогч нэг улсын нутаг дэвсгэрт саатуулагдсан, эсхүл ял эдэлж буй этгээдийг энэхүү конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан таниулах, мэдүүлэг авах болон мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт цуглуулахад туслалцаа авах зорилгоор оролцогч өөр улсын нутаг дэвсгэрт байлцуулах тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) Тухайн хүн өөрөө сайн дураар зөвшөөрсөн;
 - б) Оролцогч улсуудын тавьсан зохих шаардлагыг үндэслэн тэдгээрийн эрх бүхий байгууллагууд зөвшөөрсөн байх зэрэг хамаарна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар:
- а) Шилжүүлэн өгөх оролцогч улс өөрөөр хүссэн, эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд шилжүүлэн авах оролцогч улс нь тухайн этгээдийг цагдан хорих үүрэгтэй;
 - б) Оролцогч улсуудын эрх бүхий байгууллага өөрөөр тохиролцоогүй бол өмнө нь тохиролцсоны дагуу цагдан хоригдсон этгээдийг хүлээн авсан оролцогч улс үүргээ биелүүлж, шилжүүлэн өгөгч оролцогч улсад тухайн этгээдийг буцаан шилжүүлнэ;



- с) Шилжүүлэн авах оролцогч улс шилжүүлэн өгөх оролцогч улсаас тухайн этгээдийг шилжүүлэн авахтай холбогдуулан шилжүүлэн авах ажиллагаа явуулахыг шаардахгүй;
- д) Тухайн этгээдийн шилжүүлэн өгөх оролцогч улсад өнгөрүүлсэн хугацааг шилжүүлэн авах оролцогч улсад цагдан хоригдсон хугацаагаар тооцно.

37 дугаар зүйл. Аюулгүй байдал

1. Хүсэлт гаргасан оролцогч улсын хүсэлтийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт гарган өгөх, мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрсөн гэрч, шинжээч болон бусад этгээдийг хүсэлт хүлээн авсан оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө үйлдэл, эс үйлдэл, эсхүл ял шийтгэлтэй нь холбогдуулан хүсэлт гаргасан оролцогч улсын нутаг дэвсгэрт түүнийг мөрдөн шалгах, саатуулах, шийтгэх, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлах аливаа арга хэмжээ авахыг хориглоно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрч, шинжээч болон бусад этгээдийн аюулгүй байдал дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

(а) тухайн этгээдийг тасралтгүй 15 хоног байлцуулсан, эсхүл оролцогч улсуудын тохиролцсон хугацаанаас хойш байлцуулах шаардлагагүй болсон тухай хүсэлт гаргасан оролцогч улсын шүүх байгууллагаас албан ёсоор мэдэгдсэн өдрөөс хойших хугацаанд буцах боломж байсан хэдий ч хүсэлт гаргасан оролцогч улсын нутаг дэвсгэрт сайн дураараа үлдсэн; эсхүл

(b) хүсэлт гаргасан оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарч, өөрийн хүсэлтээр эргэн ирсэн байх зэрэг болно.

38 дугаар зүйл. Эд зүйлс, баримт бичиг, хуулга болон бусад нотлох баримт шилжүүлэх

1. Хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт авсан оролцогч улс нь хүсэлтийн дагуу эд зүйл, баримт бичиг, хуулга, эсхүл бусад нотлох баримтыг хүсэлт гаргасан оролцогч улсад шилжүүлэн өгч болно. Хүсэлт гаргасан оролцогч улсаас баримт бичиг, хуулга болон бусад нотлох баримтыг эх хувиар ирүүлэхийг хүссэн бол хүсэлт авсан оролцогч улс биелүүлэхийн тулд бүх хүчин чармайлт гаргана.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс тэдгээрийг буцаан авах эрхээсээ татгалзсанаас бусад тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс нэн даруй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсноор ойрын хугацаанд буцаан өгнө.




39 дүгээр зүйл. Мөрдөн шалгах ажиллагааны тусгай арга хэмжээ

1. Оролцогч улсууд өөрийн дотоодын эрх зүйн тогтолцооны үндсэн зарчмуудыг үндэслэн дотоодын хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагаас өөрийн нутаг дэвсгэрт энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх зорилгоор хяналттай хүргэлтийн арга хэмжээ явуулах, шаардлагатай тохиолдолд цахим хяналт болон бусад төрлийн арга хэмжээ авах зэргээр мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж болно.
2. Шаардлагатай тохиолдолд оролцогч улсууд энэхүү конвенцод заасан гэмт хэргийг мөрдөн шалгах зорилгоор олон улсын түвшинд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахаар хоёр талт болон олон талт хэлэлцээр байгуулж, хамтран ажиллаж болно. Хэлэлцээр байгуулан хэрэгжүүлэхдээ оролцогч улсын халдашгүй байдлын зарчимд бүрэн нийцүүлж, тухайн хэлэлцээрийн нөхцөлийг чанд сахиж, явуулна.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан олон улсын түвшинд мөрдөн шалгах тусгай арга хэмжээ явуулах тухай гэрээ, хэлэлцээр байхгүй тохиолдолд олон улсад мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тухай шийдвэр бүрийг хэрэг тус бүрийн онцлогийг харгалзан үзэж гаргах. Шаардлагатай гэж үзвэл хамаарах оролцогч улсуудтай тухайн улсад хэрэгжүүлэхтэй холбогдуулан санхүүгийн болон ойлголцлын асуудлыг тохиролцож болно.

40 дүгээр зүйл. Мөрдөн шалгах нууц ажиллагаа

1. Хүсэлт гаргасан болон хүлээн авсан оролцогч улсууд тэдгээрийн халхавч, эсхүл хуурамч баримт бичиг ашиглах алба хаагчдад энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахад харилцан туслалцаа үзүүлэхээр тохиролцож болно.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын эрх бүхий байгууллага түүнд хариу өгөхдөө өөрийн дотоодын хууль тогтоомж, журамд нийцүүлэн хэрэг тус бүрээр шийдвэр гаргана. Мөрдөн шалгах нууц ажиллагааны үргэлжлэх хугацаа, дэлгэрэнгүй нөхцөл болон ажиллагаа явуулах алба хаагчдын эрх зүйн байдлыг оролцогч улс орнуудын дотоодын хууль тогтоомж, журмыг харгалзан талуудын зөвшилцлийн үндсэн дээр харилцан тохиролцоно.
3. Оролцогч улсуудын нутаг дэвсгэрт явуулах мөрдөн шалгах нууц ажиллагааг өөрийн дотоодын хууль тогтоомж, журмын дагуу явуулна. Оролцогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь мөрдөн шалгах нууц ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, халхавч, эсхүл хуурамч бичиг баримт ашиглаж буй алба хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудлаар хамтран ажиллана.



4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улс бүр төв байгууллагаар дамжуулан эрх бүхий байгууллагыг мэдэгдэнэ, эсхүл 85 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан нөхцөл хангагдсан бол түр хугацаанд нэмэлт дэмжлэг үзүүлэхээр томилогдсон улсыг мэдэгдэнэ.

41 дүгээр зүйл. Хамтарсан ажлын хэсэг

1. Нэг буюу түүнээс дээш оролцогч улсад мөрдөн шалгах ажиллагаа явуулах тохиолдолд хоёр буюу түүнээс дээш оролцогч улсын эрх бүхий байгууллага харилцан тохиролцож, өөрийн дотоодын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн дагуу тодорхой зорилго, заагдсан хугацаанд мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулж болох бөгөөд нэг буюу түүнээс дээш оролцогч улс оролцсон мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар харилцан зөвшөөрснөөр сунган ажиллуулж болно.
2. Хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хэлэлцээрт зааж өгнө. Мөрдөн шалгах ажлын хэсгийг дараах тохиолдолд байгуулж болно:
 - a) Оролцогч улс энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах явцад оролцогч бусад улстай холбоотой, хүнд ээдрээтэй ажиллагаа явуулах шаардлагатай болсон;
 - b) Оролцогч хэд хэдэн улсаас энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад тэдгээр оролцогч улсуудад уялдаа зохион байгуулалттай, төвлөрсөн ажиллагаа явуулах шаардлагатай болсон.
3. Хамтарсан ажлын хэсэг байгуулах хүсэлтийг тухайн асуудал хамаарах аль ч оролцогч улс гаргаж болно. Мөрдөн шалгах ажиллагаа явагдахаар төлөвлөгдөж буй оролцогч улсад байгуулна.
4. 25 дугаар зүйлд зааснаас гадна хамтарсан ажлын хэсэг байгуулах хүсэлтэд бүрэлдэхүүн, зорилго, мөрдөн шалгах ажиллагааны үргэлжлэх хугацааг тусгана.
5. Хамтарсан ажлын хэсэг дараах ерөнхий нөхцөлийн дагуу оролцогч улсуудын нутаг дэвсгэрт ажиллана. Үүнд:
 - a) Хамтарсан ажлын хэсгийн ахлагч, эсхүл ахлагчид нь тухайн ажлын хэсгийн ажиллагаа явагдаж буй оролцогч улсаас мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй эрх бүхий байгууллагын төлөөлөгч байх;
 - b) Хамтарсан ажлын хэсгийн ахлагч, эсхүл ахлагчид дотоодын хууль тогтоомжид заасан эрх мэдлийнхээ хүрээнд ажиллах;



- с) Хамтарсан ажлын хэсэг нь ажиллагаа явагдах оролцогч улсын хууль тогтоомжийн дагуу ажиллагаа явуулна;
- д) Хамтарсан ажлын хэсгийн гишүүд болон түүнд томилогдон ирсэн гишүүд нь "а" заалтад заасан этгээдийн удирдлага доор ажиллаж, өөрийн байгууллагын ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу ажиллана;
- е) Ажиллагаа явагдаж буй оролцогч улс хамтарсан ажлын хэсэгт шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авна.
6. Энэ зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй оролцогч улсын хамтарсан ажлын хэсгийн гишүүнийг "гишүүн", оролцогч бусад улсын гишүүнийг "томилогдон ирсэн гишүүн" хэмээн тус тус тэмдэглэнэ.
7. Томилогдон ирсэн гишүүд ажиллагаа явагдаж буй улсад мөрдөн шалгах ажиллагаанд байлцах эрхтэй. Ингэхдээ ажлын хэсгийн ахлагч нь ажиллагаа явагдаж буй оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхой шалтгааны улмаас өөрөөр шийдвэрлэж болно.
8. Хамтарсан ажлын хэсгийн ажиллагаа явагдаж буй оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу ажлын хэсгийн ахлагчийн шийдвэрээр ажлын хэсэгт томилогдон ирсэн гишүүдэд тухайн улс болон томилогч оролцогч улсын эрх бүхий байгууллагаас баталсан мөрдөн шалгах тодорхой арга хэмжээ явуулж болно.
9. Хамтарсан ажлын хэсгээс оролцогч улсад явуулж буй арга хэмжээг ажлын хэсгийг байгуулагч оролцогч бусад улсын нутаг дэвсгэрт явуулах шаардлагатай болсон тохиолдолд тухайн оролцогч улсаас томилогдон ирсэн гишүүн нь өөрийн улсын эрх бүхий байгууллагад арга хэмжээ явуулахаар хүсэлт гаргана. Оролцогч улсад хүсэлтийн дагуу явуулах тухайн арга хэмжээ нь дотооддоо явуулах мөрдөн шалгах ажиллагааны адил байна.
10. Хамтарсан ажлын хэсгээс бусад оролцогч улс буюу гуравдагч улсаас туслалцаа шаардлагатай болсон тохиолдолд тухайн гуравдагч улсад хүргүүлэх хүсэлтийг оролцогч улсуудын эрх бүхий байгууллага холбогдох баримт бичиг, эсхүл хэлэлцээрийн дагуу гаргана.
11. Хамтарсан ажлын хэсэгт томилогдон ирсэн гишүүд өөрийн дотоодын хууль тогтоомж болон бүрэн эрхийнхээ хүрээнд энэ ажлын хэсэгт тухайн улсаас мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.



12. Хамтарсан ажлын хэсгийн гишүүн болон томилогдон ирсэн гишүүний хуулийн дагуу авагдсан боловч өөр оролцогч улсын эрх бүхий байгууллагад авагдаагүй мэдээ, мэдээллийг дараах зорилгоор ашиглаж болно. Үүнд:


- a) Ажлын хэсгийн зорилгыг хангах;
- b) Мэдээ, мэдээлэл авагдсан оролцогч улсын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар бусад гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах. Тухайн мэдээ, мэдээллийг ашигласнаар оролцогч улсын мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах, эсхүл тухайн оролцогч улс эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэхээс татгалзах тохиолдолд татгалзаж болно;
- c) Мөрдөн шалгах ажиллагаа явуулснаар олон нийтэд учрах байсан онц ноцтой шууд аюулаас урьдчилан сэргийлж, "b" заалттай харшлаагүй бол;
- d) Хамтарсан ажлын хэсгийг байгуулагч оролцогч улсууд харилцан тохиролцсон дагуу бусад зорилгоор ашиглаж болно.

13. Энэ зүйл нь мөрдөн шалгах ажлын хэсэг байгуулах, ажиллуулах тухай хүчин төгөлдөр үйлчилж буй бусад зүйл заалт болон хэлэлцээртэй харшлахгүй.

14. Оролцогч талуудын дотоодын хууль тогтоомжийн хүрээнд, эсхүл зөвшөөрсөн эрх зүйн баримт бичгийн дагуу хамтарсан ажлын хэсгийн үйл ажиллагаанд түүнийг байгуулагч оролцогч улсын эрх бүхий байгууллагын төлөөлөгчдөөс бусад этгээд оролцож болно. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн дагуу ажлын хэсгийн гишүүд, эсхүл томилогдон ирсэн гишүүдэд олгогдсон эрх гуравдагч этгээдүүдэд хамаарахгүй.

42 дугаар зүйл. Хил дамнасан ажиглалт


- 1. Мөрдөн шалгах ажиллагааны явцад оролцогч улсуудын хууль сахиулах байгууллагын алба хаагч ажиглалтад байгаа нэр бүхий этгээдийг энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт оролцсон байж болзошгүй гэж үзсэн, эсхүл тухайн этгээд нь өөр этгээдийг тодорхойлох, эсхүл байршлыг нь тогтооход ач холбогдолтой гэж үзсэн бол өмнө нь хүргүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийн дагуу өөр оролцогч улсын нутаг дэвсгэрт хил дамнасан ажиглалт явуулах зөвшөөрөл авч, үргэлжлүүлэн явуулж болно.
- 2. Хүсэлтийн дагуу хил дамнасан ажиглалтыг тухайн ажиллагаа явагдах оролцогч улсын эрх олгогдсон алба хаагчаар явуулж болно.
- 3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг оролцогч улсаас нэр заасан зөвшөөрөл олгох, гүйцэтгүүлэх эрхтэй байгууллагад хүргүүлнэ.



4. Хил дамнасан ажиглалтыг 1 дэх заалтад заасан нэгээс дээш алба хаагч явуулахаар бол дараах ерөнхий нөхцөлийн дагуу явуулна:
- a) Ажиглалт явуулах алба хаагчид энэ зүйл болон явагдаж буй оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө; Ингэхдээ оролцогч улсын эрх бүхий байгууллагын зааврыг дагаж мөрдөнө;
 - b) Ажиглалт явуулах алба хаагчид нь ажиглалт явуулахдаа зөвшөөрөл олгосныг нотлох батламжийг биедээ авч явна;
 - c) Ажиглалт явуулах алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байгааг ажиллагааны туршид нотолно;
 - d) Хүсэлт хүлээн авсан оролцогч улс өөрөөр шийдвэрлээгүй бол ажиглалт явуулах алба хаагчид ажиглалтын үеэр албаны галт хэрэгсэл авч явж болно; Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хууль ёсоор биеэ хамгаалахаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно;
 - e) Олон нийтийн газраас бусад орон байр, газарт нэвтрэхийг хориглоно;
 - f) Ажиглалт явуулах алба хаагчид ажиглалтад байгаа хүнийг зогсоож, байцаах, баривчлах эрхгүй;
 - g) Ажиглалт явагдсан оролцогч улсын холбогдох байгууллагад ажиллагааны талаар тайлан өгнө; Ажиглалт явуулж буй алба хаагчдыг өөрийн биеэр ирэхийг шаардаж болно;
 - h) Нутаг дэвсгэрт нь ажиглалт явагдсан тухайн улсын байгууллагаас хүсэлт ирүүлсэн тохиолдолд ажиглалт явуулсан алба хаагчийн харьяалагдах улсын байгууллага явагдсан ажиллагаатай холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, туслалцаа үзүүлнэ.
5. Энэ зүйлийн 3 дэх хэсэгт заасны дагуу оролцогч улс бүр төв байгууллагаар дамжуулан эрх бүхий байгууллагыг мэдэгдэнэ, эсхүл 85 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан нөхцөл хангагдсан бол түр хугацаанд нэмэлт дэмжлэг үзүүлэхээр томилогдсон улсыг мэдэгдэнэ.

43 дугаар зүйл. Албан тушаалтны хүлээх эрүүгийн хариуцлага

Оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол 39, 40, 41, 42 дугаар зүйлд заасан ажиллагаа явагдаж буй оролцогч улсаас бусад оролцогч улсын албан тушаалтны эсрэг, эсхүл тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэгт өөр улсын албан тушаалтан гэж үзнэ.




44 дүгээр зүйл. Албан тушаалтны хүлээх иргэний хариуцлага


1. 39, 40, 41, 42 дугаар зүйлд заасан ажиллагааг оролцогч улсын албан тушаалтнууд өөр оролцогч улсад явуулах тохиолдолд тэдгээрийн явуулсан ажиллагааны улмаас учирсан хохирлыг ажиллагаа явагдах оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу өмнөх оролцогч улсаар нөхөн төлүүлнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хохирол учирсан оролцогч улс нь өөрийн албан тушаалтнуудын учруулсан хохиролд хэрэглэгдэх нөхцөлийн адил нөхөн төлбөр төлнө.
3. Оролцогч улсын албан тушаалтнууд оролцогч бусад улсын нутаг дэвсгэрт байрлах этгээдэд хохирол учруулсан бол тухайн оролцогч улсад нөхөн төлбөр бүрэн олгох замаар тус этгээдийн хохирлыг барагдуулна.
4. Гуравдагч этгээдийн өмнө эрхээ хэрэгжүүлэхэд хохирол учруулахгүйгээр, энэ зүйлийн 3 дахь хэсгийг үл харгалзан оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд өөр оролцогч улсын учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүсэлт гаргахаас татгалзана.
5. Оролцогч улсууд өөрөөр тохиролцоогүй бол энэ зүйлийг хэрэглэнэ.

45 дугаар зүйл. Хураан авах асуудлаарх олон улсын хамтын ажиллагаа

1. Оролцогч улсад энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт холбогдуулан тухайн нутаг дэвсгэрт мөнгө угаахад ашигласан, эсхүл ашиглагдах байсан хөрөнгө, хэрэгсэл болон 83.3-т заасан хохирогчид нөхөн төлбөр болгон төлөгдөх хөрөнгө зэрэг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө болон түүнтэй тэнцэхүйц үнийн дүнтэй орлогыг хураан авах тухай хүсэлт ирүүлсэн тохиолдолд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд өргөн хэмжээнд туслалцаа үзүүлнэ.
 - а) Хураан авах шийдвэр гаргуулахаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах, тухайн шийдвэр гарсан бол түүнийг гүйцэтгэх; эсхүл
 - б) Хүсэлтийг гүйцэтгүүлэх зорилгоор хүсэлт гаргасан оролцогч улсын шүүх байгууллагаас гадаад улсын нутаг дэвсгэрт энэхүү конвенцод заасан гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгө, хэрэгсэл болон үйлдэхэд ашигласан, эсхүл ашиглагдах байсан хөрөнгө, хэрэгсэл болон 83.3-т заасан хохирогчид нөхөн төлбөр болгон төлөгдөх хөрөнгө зэрэг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө болон түүнтэй тэнцэхүйц үнийн дүнтэй орлогыг хураан авах шийдвэрийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх.



2. Энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт хэргийн харьяалал тогтоосон оролцогч өөр улсаас хүсэлт ирүүлсэн тохиолдолд оролцогч улс өөрийн дотоод хууль тогтоомжийн хүрээнд өргөн хэмжээнд туслалцаа үзүүлж, конвенцод заасан гэмт хэрэгт ашигласан, эсхүл ашиглагдах байсан хууль бус орлого, хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг илрүүлэх, тогтоох, битүүмжлэх ажиллагааг явуулж, хүсэлт гаргасан оролцогч улсын хүсэлтийн дагуу, эсхүл 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлт хүлээн авсан оролцогч улсын шийдвэрээр явцдаа хураан авах болно.
3. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хэсэгчлэн буюу бүхэлд нь хөрөнгө болгон хувиргасан, эсхүл хөрвүүлсэн бол гэмт хэргийн улмаас олсон орлогын оронд тухайн хөрөнгөд энэ зүйлд заасан арга хэмжээг авна.
4. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хууль ёсны эх үүсвэрээс олж авсан хөрөнгөтэй нэгтгэсэн бол тухайн хөрөнгийг битүүмжлэхгүйгээр гэмт хэргийн улмаас олсон, нэгтгэсэн орлогыг үнэлэн тооцож, хураан авна.
5. Энэ зүйлд заасан арга хэмжээг гэмт хэргийн улмаас олсон орлоготой адилтган гэмт хэргийн улмаас олсон орлого, ашиг, хувиргасан, хөрвүүлсэн, нэгтгэсэн хөрөнгөд авна.
6. Энэ зүйлийг хангах үүднээс оролцогч улсууд өөрийн шүүх, эсхүл эрх бүхий байгууллагад банк, санхүү болон арилжааны байгууллагаас хуулга гаргуулан авах, эсхүл битүүмжлэх эрх олгоно. Оролцогч улсууд банкны нууцлал гэх үндэслэлээр энэ хэсгийн дагуу ажиллахаас татгалзахгүй.
7. 1 дэх хэсгийг гэмт хэргийн улмаас олсон орлогын дүнтэй тэнцэхүйц хэмжээний мөнгөн дүн төлөхийг шаардан хураан авах, хүсэлт хүлээн авсан оролцогч улсад байрлах хөрөнгийг хураан авахад хэрэглэж болно. 1 дэх хэсэгт заасан хураан авах шийдвэрийг гүйцэтгэхдээ төлбөр төлөгдөөгүй бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн зорилгыг хангахын тулд хөрөнгийг нэхэмжилж болно.
8. Оролцогч улсууд өөрийн дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд хамтран ажиллаж, хүсэлтэд дурдсан ажиллагаа гүйцэтгэхдээ эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр хураан авах арга хэмжээг авч болох ба хөрөнгө нь гэмт хэргийн улмаас олсон орлого, эсхүл 3-5 хэсэгт заасан бусад хөрөнгө болох нь тогтоогдсон, тухайн арга хэмжээг авах шийдвэрийг энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт холбогдуулан хүсэлт гаргасан оролцогч улсын шүүхийн байгууллагаас гаргасан байх.
9. 25 дугаар зүйлд зааснаас гадна хүсэлт нь энэ зүйлд заасан дараах агуулгатай байна. Үүнд:
 - а) 1 дэх хэсгийн (а) дэд хэсэгт заасан хүсэлтэд хураан авах хөрөнгийн тодорхойлолт, хүсэлт гаргасан оролцогч улсаас хүсэлт хүлээн авсан



оролцогч улсад дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргуулан авахад шаардлагатай тогтоогдсон нөхцөл байдлын мэдээлэл;

- b) 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт заасан хүсэлтэд хүсэлт гаргасан оролцогч улсаас хураан авах шийдвэрийн албан ёсны хуулбар, тухайн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой тогтоогдсон нөхцөл байдал болон мэдээлэл;
- c) 2 дахь хэсэгт заасан хүсэлтэд хүсэлт гаргасан оролцогч улсаас тогтоогдсон нөхцөл байдал, хүсэж буй ажиллагааны талаар тайлбар.
10. 1, 2 дахь хэсэгт заасан шийдвэр, эсхүл ажиллагааг хүсэлт гаргасан оролцогч улс гүйцэтгэхдээ өөрийн дотоод хууль тогтоомж, журам, дүрэм, эсхүл хүсэлт гаргасан оролцогч улстай байгуулсан, хүчин төгөлдөр хоёр болон олон талт конвенц, хэлэлцээр, хэлэлцээрийн дагуу хийнэ.
11. Энэ зүйлийн заалт нь шударгаар оролцох гуравдагч этгээдийн эрхэд хохирол учруулахгүй.

46 дугаар зүйл. Нөхөн олговор

1. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс өөрийн хууль тогтоомжоор зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улсын хүсэлтээр, шударгаар оролцох гуравдагч этгээдийн эрхэд хохирол учруулахгүйгээр гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг битүүмжлэх, хураан авахад хүсэлт гаргасан оролцогч улс зөвшөөрснөөр энэхүү конвенцыг хэрэглэж болно. Хүсэлт гаргасан оролцогч улс тухайн хөрөнгийг хууль ёсны эзэмшигчид эргүүлэн олгохыг шийдвэрлэнэ.
2. Эд зүйл, баримт бичиг, хуулга, нотлох баримтыг хүсэлт гаргасан оролцогч улсад шилжүүлэн өгөхдөө түүнийг хууль ёсны эзэмшигчийн зүгээс зөвшөөрсөн тохиолдолд тухайн ажиллагаанаас өмнө, эсхүл дараа хүсэлт хүлээн авсан оролцогч улс буцаан авах эрхээсээ татгалзаж болно.

47 дугаар зүйл. Хураагдсан хөрөнгийг захиран зарцуулах

1. 45 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улсаас хураан авсан гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгийг тухайн оролцогч улс дотоодын хууль тогтоомж болон захиргааны журмын дагуу захиран зарцуулна.
2. 45 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс өөр оролцогч улсаас ирүүлсэн хүсэлтийг гүйцэтгэхдээ дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн хэмжээнд, хүсэлтийн дагуу гэмт хэргийн улмаас хураагдсан орлого, хөрөнгийг, эсхүл тухайн орлого, хөрөнгөтэй дүйцэхүйц дүн хүсэлт гаргасан оролцогч улсад буцаан олгохыг нэн тэргүүнд анхаарч үзнэ. Ингэснээр оролцогч улсууд




конвенцыг хэрэглэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох, эсхүл тухайн орлого, хөрөнгийг хууль ёсны эзэмшигчид эргүүлэн олгоно.

3. 45 дугаар зүйлд заасны дагуу оролцогч улс өөр оролцогч улсаас ирүүлсэн хүсэлтийг гүйцэтгэхдээ дотоодын хууль тогтоомж, захиргааны журмын дагуу гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгө, эсхүл түүнийг борлуулснаас олсон орлогыг тогтмол байдлаар, эсхүл тухай бүр оролцогч бусад улстай хуваалцах гэрээ байгуулан шийдвэрлэж болно.

48 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шилжүүлэх

Оролцогч улсууд энэхүү конвенцод заасан гэмт хэрэгт явуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хоорондоо шилжүүлэн өгч болох ба ингэхдээ олон улсад хэргийн харьяалалтай хэргийг шилжүүлэн өгснөөр шүүх ажиллагааны шударга байдал хангагдана.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ

49 дүгээр зүйл. Дөрөвдүгээр бүлгийн хамрах хүрээ

1. Аль нэг оролцогч улсаас гаргасан шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдагдсан этгээд хүсэлт хүлээн авсан оролцогч нөгөө улсын нутаг дэвсгэр дээр оршин байгаа тохиолдолд энэ бүлгийн заалтуудыг энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хувьд хэрэглэнэ.
2. Хүсэлт хүлээн авсан болон хүсэлт гаргасан оролцогч улсын аль алины нь дотоодын хууль тогтоомжийн дагуу тухайн гэмт хэргийг үйлдэхэд нэг жилээс доошгүй хугацаагаар хорих ял оноож байвал 51 дүгээр зүйлд харшлахгүйгээр шилжүүлэн өгөхийг зөвшөөрнө. Хэрэв хүсэлт гаргасан оролцогч улсад гэм буруутай нь нотлогдож, хорих ял оноосон тохиолдолд тухайн этгээдийн эдлэх ялын үлдсэн хугацаа доод тал нь зургаан сар байна.
3. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд гэмт хэргийн хэд хэдэн зүйл анги дурдагдаж, эдгээрийн доод тал нь нэг зүйл анги энэхүү конвенцын дагуу шилжүүлэн өгөх боломжтой гэмт хэрэгт хамаарч, бусад нь энэхүү конвенцод хамаарахгүй тохиолдолд хүсэлт хүлээн авсан оролцогч улс эдгээр бусад гэмт хэргийн тухайд энэ зүйлийн заалтыг хэрэглэж болно.
4. Оролцогч улсууд энэхүү конвенцыг хэрэглэх гэмт хэрэг бүрийг тухайн оролцогч улс өөр хоорондоо байгуулсан шилжүүлэн өгөх тухай бусад гэрээний дагуу шилжүүлэн өгөх боломжтой гэмт хэргийн тоонд оруулсан гэж үзнэ. Оролцогч улс бүр эдгээр гэмт хэргийг шилжүүлэн өгөх боломжтой гэж тооцон, энэ талаар цаашид өөр хоорондоо байгуулах шилжүүлэн өгөх тухай гэрээнд тусгаж байх үүрэг хүлээнэ.

50 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх эрх зүйн үндэслэл.

Шилжүүлэн өгөхдөө холбогдох гэрээ заавал байгуулсан байх нөхцөл тавьдаг аль нэг оролцогч улс түүнтэй ийм төрлийн гэрээ байгуулаагүй оролцогч нөгөө улсаас шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авсан бол тухайн оролцогч улс энэхүү конвенц үйлчлэх гэмт хэргийн хувьд энэхүү конвенцыг шилжүүлэн өгөх үндэслэл гэж авч үзнэ.

51 дүгээр зүйл. Шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл

1. Шилжүүлэн өгөхөөс дараах нөхцөлд татгалзана. Үүнд:

- а. хүсэлт хүлээн авсан улсын хувьд угсаа гарал, хүйс, арьс өнгө, сэтгэл санаа болон бие эрхтний бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг,



харьяалал, язгуур угсаа, улс төрийн үзэл бодол, эсхүл нийгмийн аль нэг бүлэгт харьяалагдах үндэслэлээр хүсэлтэд дурдсан этгээдийг мөрдөн шалгах, эсхүл залхаан цээрлүүлэх зорилго агуулж байна, эсхүл уг хүсэлтийг биелүүлэх нь эдгээр үндэслэлээр тухайн этгээдийн эрх зүйн байдалд хохирол учруулна гэж үзэх бодит үндэслэл байх;

- b. хүсэлт гаргасан оролцогч улс дотоодынхоо хууль тогтоомжийн дагуу цаазаар авах ял оногдуулдаг гэмт хэргийн талаар хүсэлт гаргасан байх. Гэхдээ хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид нийцэх бол дараах тохиолдол үүнд хамаарахгүй:

(i) хүсэлт гаргасан оролцогч улс цаазаар авах ял оноохгүй байх талаар үнэн зөв, бүрэн, бодит баталгаа өгсөн, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын саналын дагуу цаазаар авах ял оноохгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн байх; эсхүл

(ii) хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөх бол цаазаар авах ял оноосны дараа хүсэлт гаргасан оролцогч улс уг ялыг гүйцэтгэхгүй байх талаар үнэн зөв, бүрэн, бодит баталгаа өгсөн, эсхүл хүсэлт хүлээн авсан оролцогч улсын саналын дагуу цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх нөхцөлийг зөвшөөрсөн байх.


- c. хүсэлт хүлээн авсан оролцогч улсын шүүхийн эцсийн шийдвэрээр шилжүүлэн өгөх хүсэлтэд дурдагдсан этгээдэд ижил төрлийн гэмт хэргийн ял оноосон байх;

- d. хүсэлт гаргасан улсад тухайн шилжүүлэн өгөх этгээдэд эрүү шүүлт тулгах, түүнтэй харгис, хүнлэг бусаар, нэр төрийг гутаан доромжлох бусад байдлаар харьцах, эсхүл түүнийг залхаан цээрлүүлэх, хэргээ шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг нь ноцтой зөрчих, эсхүл хүний үндсэн эрхийг бусад хэлбэрээр ноцтой зөрчих тохиолдол гарна гэж үзэх бодит үндэслэл хүсэлт хүлээн авсан улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу үүссэн байх зэрэг тохиолдлууд хамаарна.

2. Шилжүүлэн өгөхөөс дараах нөхцөлд татгалзаж болно. Үүнд:

- a. эрэн сурвалжлагдаж буй этгээдийн хувьд хугацаанаас нь өмнө тэнсэн суллагдах боломжгүйгээр бүх насаараа хоригдох, эсхүл тодорхой бус хугацаагаар хоригдох ял авах бодит эрсдэл үүсэх;

- b. эрэн сурвалжлагдаж буй этгээд хүсэлт хүлээн авсан оролцогч улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх бүхий шүүх, эсхүл шүүх хуралдаанаар хэргээ хэлэлцүүлэхээр болсон байх;



- c. хүсэлт хүлээн авсан оролцогч улс, эсхүл аль нэг өөр улс шүүх эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх бүхий шүүх, эсхүл шүүх хуралдаанаас эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдэд эрүүгийн ижил төрлийн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр эцсийн шийдвэр гаргасан байх;
 - d. хүсэлт хүлээн авсан оролцогч улсын эрх бүхий байгууллага тухайн шилжүүлэн өгөх хүсэлтэд дурдсантай ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй гэсэн үндэслэлээр шилжүүлэн өгөх этгээдийн эсрэг шалгах ажиллагаа эхлүүлсэн байх;
 - e. шүүх эрх мэдэл хэрэгжүүлэх дүрмийн дагуу эрүүгийн хэргийг таслан шийдвэрлэх эрх бүхий шүүхээс шийдвэр гаргана гэж хүсэлт гаргасан оролцогч улсын эрх бүхий байгууллага хангалттай гэж үзэж болох баталгаа өгөөгүй ба шилжүүлэн өгөх тухайн хүсэлтийг хүсэлт гаргасан улсад онцгой тохиолдолд байгуулагдсан, эсхүл ad hoc шүүх, шүүх хуралдаанаас хүсэлт гаргасан байх;
 - f. хүсэлт хүлээн авсан оролцогч улс хэд хэдэн улс, эрх бүхий олон улсын эрүүгийн шүүх, шүүх хуралдаанаас нэгэн зэрэг хүсэлт хүлээн авч, эдгээр хүсэлтийн аль нэгийг нь зөвшөөрсөн байх;
 - g. хүсэлтийг энэхүү конвенцын заалтад нийцүүлж гаргаагүй байх;
 - h. эрэн сурвалжлагдаж буй этгээдийг хүлээлгэж өгөхөд түүний насны болон эрүүл мэндийн байдлаас шалтгаалж онц ноцтой үр дагавар үүсэж болзошгүй байх;
 - i. 11 дүгээр зүйлд харшлахгүйгээр хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан ба энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байх;
 - j. хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн хүсэлтийг биелүүлэх нь бүрэн эрх байдал, аюулгүй байдал, нийтийн дэг журам болон бусад чухал эрх ашигт харшлах магадлалтай гэж үзсэн байх зэрэг тохиолдлууд хамаарна.
3. Энэ зүйлд заасны дагуу татгалзах, эсхүл 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу биелүүлэхийг хойшлуулах шийдвэр гаргахаасаа өмнө хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь шаардлагатай зарим болзол нөхцөлийг дагаж мөрдсөн тохиолдолд шилжүүлэн өгөхийг зөвшөөрч болох эсэх талаар хүсэлт гаргасан оролцогч улстай зөвлөлдөнө. Хэрэв тавигдсан болзол нөхцөлийн дагуу шилжүүлэн авахаа зөвшөөрсөн бол хүсэлт гаргасан оролцогч улс эдгээр болзол нөхцөлийг дагаж мөрдөнө.



52 дугаар зүйл. Тусгаарлах зарчим

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн ба шилжүүлэн өгөхтэй холбоогүй аливаа гэмт хэрэгт холбогдуулан түүнийг мөрдөн шалгаж, ял оноож, эсхүл саатуулахгүй, мөн дараах тохиолдлоос бусад үед аливаа өөр шалтгаанаар түүний хувийн эрх чөлөөг нь хязгаарлахгүй. Үүнд:
 - а) Тухайн этгээдийг шилжүүлэн өгсөн оролцогч улс зөвшөөрсөн байх. Ийм зөвшөөрөл авах хүсэлтийг 56 дугаар зүйлд дурдагдсан баримт бичиг болон тухайн этгээдийг шилжүүлэн өгөх оролцогч улсаас шаардсан бусад нэмэлт мэдээллийн хамт мэдүүлнэ ;
 - б) тухайн этгээд шилжүүлэн өгсөн оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарах боломж олгосон боловч түүнийг сулласан өдрөөс хойш 45 хоногийн дотор гаргаагүй, эсхүл гарсныхаа дараагаар тус улсад буцаж ирсэн байх зэрэг орно.
2. 1 дэх хэсэгт заасныг үл харгалзан хүсэлт гаргасан оролцогч улс шаардлагатай бол тухайн этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээс гаргах, эсхүл цаг хугацааны хүчин зүйлээс хамаарч эрх зүйн үр дагавар үүсэхээс урьдчилан сэргийлэх үүднээс in absentia хэрэг хянаг шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх зэрэг дотоодын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.
3. Хэргийг хянан шалгах ажиллагааны үед яллах дүгнэлтэд орсон хэргийн тодорхойлолт өөрчлөгдсөн бол уг шинэ тодорхойлолтын дагуу үйлдсэн байж болзошгүй гэмт үйлдэл нь шилжүүлэн өгөх боломжтой гэмт хэрэг бүрдүүлж байгаа тохиолдолд л тухайн шилжүүлэн өгөх этгээдийн хэргийг хянан шалгаж, түүнд ял шийтгэл онооно.

53 дугаар зүйл. Гуравдагч улс уруу дахин шилжүүлэх

Энэхүү конвенцын 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс шилжүүлэн өгсөн бөгөөд шилжүүлэн өгөхөөс өмнө оролцогч өөр улс, эсхүл гуравдагч улсад үлдсэн гэмт хэрэгтэй холбогдуулан эрэн сурвалжлагдаж байгаа тухайн этгээдийг хүсэлт хүлээн авсан оролцогч улсын зөвшөөрөлгүйгээр аль нэг өөр оролцогч улс, эсхүл гуравдагч улсад хүлээлгэн өгөхийг хориглоно. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт бичигтэй танилцахыг шаардаж болно.

54 дүгээр зүйл. Харьяатыг шилжүүлэн өгөх

1. Иргэний харьяалалыг үндэслэн шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно. Уг үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд 14 дүгээр зүйл үйлчилнэ.



2. Оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу өөр улсын шүүх хуралдаан, эсхүл шилжүүлэн өгөх ба хүлээлгэн өгөх хүсэлт гаргасантай холбоотойгоор хянан шийдвэрлэх ажиллагааны дүнгээр оноох ялыг эх оронд нь эдлүүлэхээр буцаан авах болзолтойгоор өөрийн улсын харьяатыг шилжүүлэх, эсхүл өөр хэлбэрээр хүлээлгэн өгөхийг зөвшөөрдөг ба хүсэлт гаргасан тухайн оролцогч улс энэ болон холбогдох бусад оролцогч улсын зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад болзлыг хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд шилжүүлэн, эсхүл хүлээлгэн өгөх ажиллагааг 14 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу хэрэгжүүлэхэд хангалттай байна.


3. Оноосон ялыг эдлүүлэх зорилгоор шилжүүлэн авах хүсэлт гаргасан ба уг хүсэлтийг хүлээн авсан оролцогч улс холбогдох этгээдийг өөрийн харьяат иргэн гэдэг үндэслэлээр шилжүүлэн өгөхөөс татгалзсан бол хүсэлт хүлээн авсан тухайн оролцогч улс өөрийн дотоодын хууль тогтоомж зөвшөөрч байгаа тохиолдолд оролцогч нөгөө улсаас гаргасан хүсэлтийн дагуу уг улсын дотоодын хууль тогтоомжоор оноосон ял, эсхүл 75-79 дүгээр зүйлийн дагуу үлдсэн хугацааны ялыг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

55 дугаар зүйл. Хүсэлтийг гүйцэтгэх

1. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг түүнийг хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон болзлын дагуу гүйцэтгэнэ.
2. Хэрэв хүсэлт хүлээн авсан оролцогч улс шилжүүлэн өгөх талаар гаргасан хүсэлтэд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзаж, эсхүл уг хүсэлтийг гүйцэтгэхийг хойшлуулсан бол ийнхүү татгалзах, эсхүл хойшлуулах болсон үндэслэлээ зохих тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улсад мэдэгдэнэ.

56 дугаар зүйл. Хүсэлт болон хавсаргах баримт бичиг

1. Хүлээн авах оролцогч улс хүсэлтийн үнэн зөвийг тогтоох боломжтой байдлаар шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг бичгээр үйлдэнэ.
2. Шилжүүлэн өгөх тухай хүсэлт дараах зүйлийг агуулж, эсхүл хавсаргасан байна. Үүнд:
 - а) хүсэлтэд дурдагдсан этгээдийн талаарх дүрслэл болон түүний хувийн байдал, харьяалал, байгаа газрыг тогтооход нэмэр болох бусад мэдээлэл;
 - б) тухайн гэмт хэргийг тодорхойлсон хуулийн холбогдох зүйл анги, шаардлагатай бол гэмт хэрэгтэй холбоотой хуулийн заалтын тайлбар болон оноох ялын талаарх тайлбар;
 - в) хэрэв тухайн этгээдийг гэмт хэрэгт үйлдсэн гэж сэжиглэж байгаа бол шүүх, эсхүл эрх бүхий холбогдох өөр байгууллагаас гаргасан баривчлах тухай шийдвэр, эсхүл түүний баталгаажуулсан хуулбар, шилжүүлэн өгөх тухай



хүсэлтэд холбогдолтой гэмт хэргийн талаарх тайлбар, гэмт хэрэг гарсан огноо болон газрын тухай мэдээлэл бүхий гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эсхүл эс үйлдлийн талаарх тодорхойлолт;

- d) хэрэв тухайн этгээдэд ял оноосон бол, шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд холбогдолтой гэмт хэргийн тухай тайлбар, гэмт хэрэг гарсан огноо болон газрын тухай мэдээлэл бүхий гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эсхүл эс үйлдлийн талаарх тодорхойлолт, үйлдсэн гэм буруу, оноосон ял, ялыг гүйцэтгэх үндэслэл, ял эдлэх хугацааг тогтоосон шүүхийн шийдвэр, эсхүл өөр төрлийн баримт бичиг;
 - e) хэрэв тухайн этгээдэд in absentia зарчмаар ял оноосон бол энэ зүйлийн (d) дэд хэсэгт заасан баримт бичгээс гадна тухайн этгээд биеэрээ байлцан хэргээ дахин хянан хэлэлцүүлэх, эсхүл давж заалдах эрхтэй хамаатай өмгөөллийн зорилгоор ашиглагдах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед тавигдах шаардлага, баталгаа, бусад эрх зүйн хэрэгслийн талаарх тайлбар;
 - f) хэрэв тухайн этгээдийн гэм буруу нь тогтоогдож, харин түүнд ял оноогоогүй байгаа тохиолдолд шилжүүлэн өгөхтэй холбоотой гэмт хэргийн талаарх тайлбар, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эсхүл эс үйлдлийн тодорхойлолт, гэм бурууг тогтоосон тухай баримт бичиг болон ял оноохоор төлөвлөж байгааг нотолсон тайлбар;
 - g) хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл ба/ эсхүл нотлох баримт зэрэг болно.
3. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг дагалдуулан ирүүлсэн мэдээлэл шийдвэр гаргах, эсхүл хүсэлтийг биелүүлэхэд хангалтгүй байна гэж үзвэл зохих хугацаанд нэмэлт мэдээлэл ирүүлэх талаар хүсэлт тавьж болно.

57 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийн нууцлал

Хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн хүсэлтийг биелүүлэхэд шаардагдахаас бусад үед хүсэлтэд дурдсан баримт болон хүсэлтийн үндсэн агуулгын нууцлалыг хадгална. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нууцлал хадгалах шаардлагыг хангаж чадахгүй бол энэ талаар хүсэлт гаргасан оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ. Хүсэлт гаргасан оролцогч улс уг үүссэн нөхцөл байдлыг үл харгалзан тухайн хүсэлтийг үргэлжлүүлэн биелүүлэх эсэхийг шийднэ.

58 дугаар зүйл. Зэрэгцсэн хүсэлт

1. Хэрэв нэгээс дээш оролцогч улс, эсхүл эрх бүхий олон улсын эрүүгийн шүүх, шүүх хуралдаанаас нэг, эсхүл хэд хэдэн өөр гэмт хэрэгтэй холбогдуулан




шилжүүлэн, эсхүл хүлээлгэн өгөх тухай хүсэлтийг нэгэн зэрэг гаргасан бол, хүсэлт хүлээн авсан оролцогч улс өөрийн дагаж мөрдөж байгаа олон улсын эрх зүйн баримт бичгийн дагуу хэргийн харьяалалыг эрэмбэлэн тогтоох талаар хүлээсэн үүргээ харгалзан үзэж зохих шийдвэр гаргана.

2. Хэрэв ийм төрлийн үүрэг хүлээгээгүй бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн гэмт хэргийн хүнд ноцтой байдал, үйлдсэн газар, хүсэлт гаргасан огноо, хүсэлтэд дурдагдсан этгээдийн иргэний харьяалал болон тухайн этгээдийг оролцогч өөр улс руу шилжүүлэн өгөх боломж зэрэг холбогдох нөхцөл байдлыг харгалзан үзэж зохих шийдвэр гаргана.

59 дугаар зүйл. Түр саатуулах

1. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь хэрэв нөхцөл байдал үүсэж, яаралтай арга хэмжээ авахыг шаардаж байгаа бол хүсэлт гаргасан оролцогч улсын хүсэлтээр өөрийн нутаг дэвсгэрт байгаа шилжүүлэн өгөх тухайн этгээдийг саатуулах, эсхүл түүнийг шилжүүлэн өгөх ажиллагаанд биечлэн байлцуулахад шаардлагатай өөр төрлийн арга хэмжээг авч болно.
2. Түр саатуулах тухай хүсэлтэд дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - а) хэрэв хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай бол 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (а)-гаас (с) хүртлэх дэд хэсэгт дурдсан мэдээлэл;
 - б) хүсэлтэд холбогдох гэмт хэрэг болон үндэслэл болох баримтуудын талаарх тодорхойлолт;
 - в) 56 дугаар зүйлд заасан баримт бичиг байгаа тухай мэдэгдэл;
 - г) тухайн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг албан ёсоор нөхөж өгөх тухай мэдэгдэл зэрэг орно.
3. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь түр саатуулах тухай хүсэлтийг хэрхэн шийдвэрлэж байгаа явцын талаар хугацаа алдалгүйгээр хүсэлт гаргасан оролцогч улсад мэдээлнэ.
4. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн этгээдийг саатуулсан өдрөөс хойш 60 хоногийн дотор түүнийг шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлт хүлээн аваагүй тохиолдолд түр саатуулах арга хэмжээг цуцална. Тухайн этгээдийг ямар ч үед түр суллах боломжтой ба ингэх тохиолдолд хүсэлт хүлээн авсан оролцогч улс уг этгээдийг оргон зайлахаас урьдчилан сэргийлэх үүднээс зохистой гэж үзсэн аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу түр саатуулах арга хэмжээг цуцлах тухай шийдвэр нь шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлт хүлээн авсны дараа хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн этгээдийг дахин саатуулж, шилжүүлэн өгөхөд нөлөөлөхгүй.

60 дугаар зүйл. Саатуулах хугацааг харгалзан үзэх


Хүсэлт гаргасан оролцогч улсын зүгээс тухайн этгээдийн эдлэх хорих ялын, эсхүл шүүхийн шийдвэрээр саатуулах нийт хугацааг тооцохдоо шилжүүлэн өгөх хүсэлтийг биелүүлэхтэй холбоотойгоор хүсэлт хүлээн авсан оролцогч улсад түүнийг саатуулсан бүх хугацааг дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөх хамгийн боломжит хүрээнд харгалзан үзэж байхыг дэмжинэ.

61 дүгээр зүйл. Шилжүүлэгдэх этгээдийг хүлээлгэн өгөх

1. Хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргасан оролцогч улс болон хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн этгээдийг хүлээлгэн өгөх өдөр, газрыг зөвлөлдөж, тохирно. Хүлээлгэн өгөх зорилгоор тухайн этгээдийг саатуулж байсан хугацааг хүсэлт гаргасан оролцогч улсад мэдэгдэнэ.
2. Эрэн сурвалжлагдаж байгаа тухайн этгээдийг товлосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар тухайн этгээдийг 30 хоногийн дараа чөлөөлж болох ба хэрэв 45 хоног өнгөрсөн бол хүсэлт хүлээн авсан улсын зүгээс өөрөөр заагаагүй тохиолдолд шууд чөлөөлнө. Тухайн этгээдийг ижил төрлийн гэмт хэрэгт холбогдуулан шалгах бол хүсэлт хүлээн авсан оролцогч улс түүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.
3. Оролцогч улсаас үл хамаарах нөхцөл байдлын улмаас шилжүүлэн өгөх тухайн этгээдийг хүлээлгэн өгөх, эсхүл хүлээн авах боломжгүй болсон тохиолдолд энэ талаар оролцогч нөгөө улсад мэдэгдэнэ. Холбогдох оролцогч улс хоорондоо зөвлөлдөж, хүлээлгэн өгөх шинэ хугацааг тохирч болох бөгөөд энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт үйлчилнэ.

62 дугаар зүйл. Хүлээлгэн өгөхийг хойшлуулах, эсхүл түр хугацаагаар хүлээлгэн өгөх

1. Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийн талаар шийдвэр гаргасны дараа хүсэлт хүлээн авсан оролцогч улс шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсанаас өөр гэмт хэрэгтэй холбогдуулан тухайн этгээдийг шалгах, эсхүл тухайн этгээдэд ял оноосон бол өөрийн нутаг дэвсгэрт ялыг эдлүүлэх зорилгоор хүлээлгэн өгөх ажиллагааг хойшлуулж болно.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүлээлгэн өгөх ажиллагааг хойшлуулахын оронд холбогдох оролцогч улстай харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийг хүсэлт гаргасан оролцогч улсад түр хугацаагаар




хүлээлгэн өгч болно.

63 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх хялбаршуулсан журам

Хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийг шилжүүлэн өгөх нь илт хориглоогүй ба тухайн этгээд хүсэлт хүлээн авсан оролцогч улсын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу түүнийг шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт хүлээн авсан оролцогч улс хялбаршуулсан журмаар шилжүүлэн өгөхийг зөвшөөрч болно.

64 дүгээр зүйл. Эд хөрөнгө хүлээлгэн өгөх

1. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс хүсэлт гаргасан оролцогч улс хандсаны дагуу дотоодын хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөх хүрээнд дараах эд хөрөнгийг хураан авч, хүлээлгэн өгнө. Үүнд:
 - а) нотлох баримт болж ашиглагдах, эсхүл
 - б) гэмт хэрэг үйлдэж олсон ба саатуулах үед эрэн сурвалжлагдаж буй тухайн этгээдийн биед нь байсан, эсхүл үүний дараа илэрсэн зэрэг эд зүйл хамаарна.
2. Эрэн сурвалжлагдаж буй этгээд нас барсан, ор сураггүй болсон, эсхүл оргон зайлсан зэрэг шалтгааны улмаас өмнө нь зөвшөөрөгдсөн шилжүүлэн өгөх ажиллагаа хэрэгжих боломжгүй болсон бол үүнийг үл харгалзан энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эд хөрөнгийг хүсэлт гаргасан оролцогч улсад хүлээлгэн өгч болно.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эд хөрөнгийг хүсэлт хүлээн авсан оролцогч улсын нутаг дэвсгэр дээр битүүмжилж, эсхүл хураан авсан бол тухайн оролцогч улс одоо явагдаж байгаа эрүүгийн хэргийн хянан шалгах ажиллагаатай холбогдуулан уг эд хөрөнгийг үргэлжлүүлэн хадгалах, эсхүл буцаан авах болзолтойгоор хүсэлт гаргасан оролцогч улсад хүлээлгэн өгч болно.
4. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс, эсхүл гуравдагч этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан эд хөрөнгөтэй холбоотой аль нэг эрхийг зүй ёсоор олж авсан тохиолдолд тухайн улсын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу уг эрхийг хамгаална. Хэрэв өмч хөрөнгөтэй холбоотой ийм эрх өмнө үүссэн бол хүсэлт гаргасан оролцогч улс хэргийг хянах ажиллагаа дууссаны дараагаар өмч хөрөнгийг нэн даруй, үнэ төлбөргүйгээр хүсэлт хүлээн авсан оролцогч улсад буцааж өгнө.



65 дугаар зүйл. Шилжүүлэн өгөх этгээдийг дамжин өнгөрүүлэх

1. Шилжүүлэн өгөх этгээдийг оролцогч өөр улсын газар нутгаар дамжин өнгөрүүлэх шаардлагатай байгаа тохиолдолд шилжүүлэн авч байгаа оролцогч улс нь оролцогч нөгөө улсад хандан түүний нутаг дэвсгэрээр дамжин тухайн этгээдийг тээвэрлэх зөвшөөрөл авах хүсэлтийг бичгээр гаргана. Хэрэв агаарын хөлгөөр тээвэрлэж, оролцогч нөгөө улсын нутаг дэвсгэр дээр төлөвлөсөн буулт хийхгүй бол энэ заалт үйлчлэхгүй.
2. Дамжин өнгөрөх хүсэлт хүлээн авсан тохиолдолд тухайн оролцогч улс уг хүсэлтийг дотоодын хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ. Уг хүсэлтийг хүлээн авсан оролцогч улс нь түүний язгуур эрх ашиг хөндөгдөхөөс бусад тохиолдолд хурдавчилсан байдлаар зөвшөөрөл олгоно.
3. Тухайн этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлж байгаа оролцогч улс түүний холбогдох хууль тогтоомжийн дагуу дамжин тээвэрлэх хугацаанд уг этгээдийг саатуулахыг зөвшөөрдөг болох талаар баталгаа гаргана.
4. Аль нэг оролцогч улсад төлөвлөөгүй буулт хийсэн тохиолдолд тухайн оролцогч улс нь харгалзах үүрэгтэй албан тушаалтны хүсэлтээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан дамжин өнгөрүүлэх хүсэлт хүлээн авах хүртэл дотоодын хууль тогтоомжийн зөвшөөрөх хугацаанд шилжүүлэн өгөх тухайн этгээдийг хорионд байлгаж болно.
5. Шилжүүлэн өгөх этгээдийн амь насанд аюул занал учирч болзошгүй, эсхүл гарал үүсэл, хүйс, арьсны өнгө, сэтгэл санааны болон биеийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, харьяалал, үндэс угсаа, улс төрийн итгэл үнэмшил, нийгмийн тодорхой бүлэгт хамаарагдах байдал зэрэг үндэслэлээр тухайн этгээдийн эрх нь зөрчигдөх эрсдэлтэй гэж үзэх аливаа газар нутгаар түүнийг дамжин тээвэрлэхгүй.
6. Оролцогч улс тус улсын харьяатыг түүний нутаг дэвсгэрээр дамжин тээвэрлэх хүсэлтэд татгалзсан хариу өгч болно.




ТАВДУГААР БҮЛЭГ. ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ

66 дугаар зүйл. Тавдугаар бүлгийн хамрах хүрээ болон ялтан шилжүүлэхтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолт

1. Дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимд нийцэж, түүний дагуу зөвшөөрөгдөх бол энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэгт холбогдож, оролцогч аль нэг улсад ял авсан этгээдийг уг ялыг эдлүүлэхээр оролцогч нөгөө улсад шилжүүлэн өгч болно. Энэхүү конвенцод хамаарах гэмт хэргээс гадна бусад төрлийн гэмт хэргийг хамтатган ял оноосон тохиолдолд мөн шилжүүлэн өгч болно.
2. Энэхүү конвенцын энэ бүлгийн зорилгын хүрээнд:
 - а) “Ял эдлүүлэх оролцогч улс” гэж ял эдлүүлэх зорилгоор тухайн ялтныг шилжүүлэн өгч болох, эсхүл шилжүүлэн авсан оролцогч улсыг;
 - б) “Шийтгэх тогтоол” гэж ял оногдуулсан бөгөөд энгийн журмаар эрх зүйн хамгаалалтын бүх арга хэрэгслийг ашиглаж, улмаар эцсийн болсон шүүхийн шийдвэр, эсхүл захирамжийг;
 - в) “Ял” гэж энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг үйлдсэний төлөө шүүхээс эрх чөлөөг хязгаарлахтай холбоотойгоор оноосон аливаа шийтгэл, арга хэмжээг;
 - г) “Ял оноосон оролцогч улс” гэж тухайн ялыг оноосон газар харьяалалд нь хамаарах оролцогч улсыг тус тус хэлнэ.

67 дугаар зүйл. Шилжүүлэх нөхцөл

1. Ял оноосон, эсхүл ял эдлүүлэх оролцогч улсаас шилжүүлэн авах хүсэлт гаргаж болно.
2. Ялтан этгээд нь энэхүү конвенцын дагуу шилжүүлэгдэх сонирхолтой байгаагаа ял оноосон, эсхүл ял эдлүүлэх оролцогч улсад хандан илэрхийлж болно.
3. Ялтанг зөвхөн дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд энэхүү конвенцын дагуу шилжүүлэн өгч болно. Үүнд:
 - (а) ялтан этгээд нь ял эдлүүлэх оролцогч улсын харьяат байх, мөн 9 дүгээр зүйлийн заалт үйлчлэх тохиолдол гарах;
 - (б) Шийтгэх тогтоол нь эцсийн шийдвэр байх;



(с) Шилжүүлэн авах хүсэлтийг хүлээн авах үед ял эдлэх хугацаа доод тал нь 6 сар, эсхүл ялын хугацааг тогтоогоогүй байх;

(d) 71 болон 72 дүгээр зүйлд харшлахгүйгээр шилжүүлэн өгөхийг ялтан этгээд өөрөө зөвшөөрсөн, эсхүл түүний нас, биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг харгалзан ял оноосон, эсхүл ял эдлүүлэх оролцогч улс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн ялтан этгээдийн хууль ёсны төлөөлөгч зөвшөөрсөн байх;

(е) ял оноосон болон ял эдлүүлэх улс шилжүүлэн өгөхийг тохирсон байх зэрэг хамаарна.

4. Ял эдлэх хугацаа энэ зүйлийн 3 дахь хэсгийн (с) дэд хэсэгт заасан хугацаанаас богино байгаа бол оролцогч улсууд шилжүүлэн өгөх талаар онцгой тохиолдолд харилцан тохирч болно.
5. Хэрэв гэрээний үндсэн дээр ялтан шилжүүлдэг аль нэг оролцогч улс түүнтэй ийм төрлийн гэрээ байгуулаагүй нөгөө оролцогч улсаас ялтан шилжүүлэн авах хүсэлт хүлээн авах тохиолдолд тухайн оролцогч улс энэхүү конвенцод хамаарах гэмт хэрэг үйлдэж, ял авсан этгээдийг шилжүүлэн өгөхдөө энэхүү конвенцыг эрх зүйн үндэслэл гэж тооцож үзнэ.

68 дугаар зүйл. Мэдээлэл өгөх үүрэг


1. Энэхүү конвенц үйлчлэх ялтан бүр энэхүү конвенцын энэ бүлгийн агуулгын талаар мэдээллийг ял оноосон оролцогч улсаас авах эрхтэй.
2. Ялтан этгээд энэхүү конвенцын дагуу шилжүүлэгдэх сонирхлоо ял оноосон улсад илэрхийлсэн бол тухайн оролцогч улс шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсны дараа ял эдлүүлэх оролцогч улсад хандан энэ талаар мэдээлэл хүргүүлнэ.
3. Энэхүү мэдээлэлд:
 - a) ялтны нэр, төрсөн огноо болон газар, 9 дүгээр зүйлийн заалт үйлчлэх тохиолдолд иргэний харьяалал;
 - b) хэрэв байгаа тохиолдолд ял эдлүүлэх оролцогч улсад тухайн ялтны байрлаж байсан хаяг;
 - c) ял онооход үндэслэл болсон баримтуудын тодорхойлолт;
 - d) ялын шинж чанар, үргэлжлэх хугацаа, үйлчилж эхэлсэн огноо;
 - e) ял эдэлсэн хугацаа болон ял оноосон оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу ялын хугацааг багасгаж болох аливаа хасалт;



- f) Шаардлагатай бол энэхүү конвенцыг үндэслэн шилжүүлэх авах хүсэлт гаргасан тухай мэдэгдэл зэргийг багтаана.
4. Ялтан нь энэхүү конвенцын дагуу шилжүүлэгдэх сонирхлоо ял эдлүүлэх улсад илэрхийлсэн бол ял эдлүүлэх оролцогч улсаас хүсэлт гаргах тохиолдолд ял оноосон оролцогч улс энэ зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан мэдээллийг түүнд хүргүүлнэ.
5. Энэ зүйлийн заалтын дагуу ял оноосон оролцогч улс, эсхүл ял эдлүүлэх оролцогч улс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, энэ хоёр оролцогч улсын зүгээс шилжүүлэн өгөх хүсэлттэй холбоотойгоор гаргасан аливаа шийдвэрийн талаарх мэдээллийг тухайн ялтанд бичгээр хүргүүлнэ.

69 дүгээр зүйл. Хүсэлт, хүсэлтийн хариу, хавсаргах баримт бичиг

1. Ялтан шилжүүлэн авах хүсэлт болон түүний хариуг бичгээр үйлдэнэ.
2. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс нь шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан эсэх шийдвэрээ хүсэлт гаргасан оролцогч улсад даруй мэдэгдэх бөгөөд тодруулга хүссэн тохиолдолд хэрэв боломжтой бөгөөд тохиромжтой байгаа бол татгалзсан шалтгаанаа тайлбарлана.
3. Ял эдлүүлэх оролцогч улс нь ял оноосон улсын хүсэлтээр дараах баримт бичгийг гаргаж өгнө. Үүнд:
- a) тухайн ялтан ял эдлүүлэх улсын харьяат болохыг, мөн 9 дүгээр зүйлийн үйлчлэлийн дагуу харьяат болохыг гэрчилсэн баримт бичиг, эсхүл мэдэгдэл;
 - b) ял оноосон оролцогч улсад ялын шийтгэл хүлээсэн тухайн үйлдэл, эсхүл эс үйлдлийг ял эдлүүлэх улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж тооцож байгаа, эсхүл ийм төрлийн үйлдэл, эс үйлдлийг харьяа нутаг дэвсгэр дээр үйлдсэн тохиолдолд түүнийг гэмт хэрэг гэж тооцох талаар зохицуулсан ял эдлүүлэх оролцогч улсын дотоодын хуулийн заалтын хуулбар;
 - c) шилжүүлэн авсны дараа ялыг хэрхэн эдлүүлэх тухай мэдээлэл болон шаардлагатай бол ялыг үргэлжлүүлэн эдлүүлэх болон шилжүүлэн тооцохыг зохицуулсан дотоодын хуулийн заалтын хуулбар;
 - d) Болзол нөхцөлтэйгөөр, эсхүл ял эдлэх хугацаанаас өмнө суллахтай холбоотой мэдээлэл болон үүнийг зохицуулах дотоодын хуулийн заалт зэрэг орно.
4. Хүсэлт хүлээн авсан оролцогч улс ялтанг шилжүүлэн өгөхөөс татгалзахаас бусад үед ялтан шилжүүлэх авах хүсэлт хүлээн авсан бол ял оноосон оролцогч улс ял эдлүүлэх оролцогч улсад дараах баримт бичгийг хүргүүлнэ. Үүнд.




- a) Шийтгэх тогтоолын баталгаат хуулбар болон уг тогтоолын үндэслэл болгож хэрэглэсэн дотоодын хуулийн холбогдох заалтуудын хуулбар;
 - b) шүүх хуралдаанаас өмнө саатуулсан эсэх, ялыг хөнгөвчлөх болон ялыг гүйцэтгэхтэй холбоотой бусад хүчин зүйлийн талаарх мэдээлэл багтаасан ял эдэлсэн хугацааны тухай мэдэгдэл;
 - c) 71, 72 дугаар зүйлд хамааруулахгүйгээр 67 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн (d) дэд хэсэгт заасны дагуу шилжүүлэн өгөх зөвшөөрөл олгосон тухай бичгээр үйлдсэн мэдэгдэл;
 - d) зохих тохиолдолд ялтны талаарх эмнэлгийн, эсхүл зан харилцааны тодорхойлолт, ял оноосон оролцогч улсад үзүүлсэн эмчилгээний талаарх мэдээлэл болон ял эдлүүлэх оролцогч улсад цаашид үзүүлэх эмчилгээний талаарх зөвлөмж зэрэг орно.
5. Оролцогч улсын аль аль нь ялтан шилжүүлэн авах хүсэлт гаргахаас өмнө, эсхүл шилжүүлэн өгөхийг зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн тухай шийдвэр гаргахаас өмнө энэ зүйлийн 3, эсхүл 4 дэх хэсэгт заасан баримт бичиг болон тодорхойлолт өгөх тухай хүсэлт гаргаж болно.

70 дугаар зүйл. Зөвшөөрөл болон түүнийг хянан шалгах

1. Ял оноосон оролцогч улс энэхүү конвенцын 67 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн (d) дэд хэсэгт заасны дагуу шилжүүлүүлэгдэх эсэхээ зөвшөөрөх этгээд уг шийдвэрээ сайн дураар бөгөөд гарах эрх зүйн үр дагаврыг бүрэн ухамсарласны үндсэн дээр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ. Ийм зөвшөөрөл өгөх журмыг ял оноосон улсын дотоодын хуулиар тогтооно.
2. Ял оноосон улс ял эдлүүлэх улс өөрийн консул, эсхүл тохиролцсоны дагуу эрх бүхий албан өөр тушаалтнаар дамжуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөлийн дагуу зөвшөөрөл өгсөн эсэхийг хянан шалгах боломжийг ял эдлүүлэх улсад олгоно.

71 дүгээр зүйл. Ял оноосон оролцогч улсыг орхин гарсан этгээд

1. Аль нэг оролцогч улсын харьяат ял эдлэх шаардлагатай байгаа бол ял оноосон улс тухайн этгээдийн харьяаллын улсад хандан оноосон ялыг гүйцэтгэх хүсэлтийг дараах тохиолдолд гаргаж болно. Үүнд:
 - a) холбогдох этгээд ял оноосон улсад түүний эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буйг мэдсэн хэдий ч өөрийн харьяаллын улс уруу оргон зайлсан, эсхүл өөр байдлаар эргэн очсон байх;
 - b) холбогдох этгээд ял оноосон улсад түүний шийтгэх тогтоол гарсныг мэдсэн хэдий ч өөрийн харьяаллын улс уруу оргон зайлсан, эсхүл өөр байдлаар




эргэн очсон байх зэрэг хамаарна.

2. Ял эдлүүлэх оролцогч улс хүсэлтэд хавсрах баримт бичгийг хүлээн авахаас өмнө, эсхүл уг хүсэлтийн талаар шийдвэр гаргахаас өмнө ял оноосон улсын хүсэлтээр тухайн ялтанг түр хорих, эсхүл шийдвэр хүлээгдэж байгаа хугацаанд түүнийг өөрийн нутаг дэвсгэрээс гаргахгүй байх өөр төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж болно. Ийм түр зуурын чанартай арга хэмжээ авахыг хүссэн бол 68 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хавсаргаж хүргүүлнэ. Ялтан этгээдийг энэ хэсгийн дагуу түр хорих нь түүний ялыг хүндрүүлэх хүчин зүйл болохгүй.
3. Энэ зүйлийн дагуу ял эдлүүлэхээр шилжүүлэн өгч байгаа бол ялтнаас зөвшөөрөл авахыг шаардахгүй.
4. Энэ зүйлд дурдсан нөхцөл байдал үүсэх үед тухайн ялтны харьяалагдах улс ял эдлүүлэх үүргийг шилжүүлэн авах тухай заасан заалт энэ зүйлд ороогүй болно.

**72 дугаар зүйл. Албадан, эсхүл нэн даруй гаргах
шаардлагатай байгаа ялтан**

1. Хэрэв ялтан этгээдэд оноосон, эсхүл уг ялын дагалдаж гарсан захиргааны шийдвэрт хорих ангиас суллагдсаны түүнийг нэн даруй, эсхүл албадан гаргах, эсхүл ял оноосон оролцогч улсын нутаг дэвсгэр дээр түүнийг үргэлжлүүлэн байлгахгүй байх өөр арга хэмжээ авах талаар заасан бол ял эдлүүлэх оролцогч улс ял оноосон оролцогч улсын хүсэлтээр тухайн ялтан этгээдээс зөвшөөрөл авалгүйгээр түүнийг шилжүүлэн авахыг энэ зүйлийн заалтыг баримтлан зөвшөөрч болно.
2. Ял эдлүүлэх оролцогч улс зөвхөн тухайн ялтны саналыг зохих ёсоор судалж үзсэний дараагаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шилжүүлэн өгөх ажиллагааг зөвшөөрнө.
3. Энэ зүйлийн зорилтын хүрээнд ял оноосон оролцогч улс нь ял эдлүүлэх оролцогч улсад дараах зүйлийг хүлээлгэн өгнө. Үүнд:
 - a. санал болгож буй шилжүүлэн өгөх ажиллагааны талаар ялтан этгээдийн илэрхийлсэн санал бодлыг тусгасан мэдэгдэл;
 - b. ялтан этгээдийг хорих ангиас суллагдсаны дараа түүнийг нэн даруй, эсхүл албадан гаргах тухай эцсийн шийдвэр, эсхүл ял оноосон оролцогч улсын нутаг дэвсгэр дээр цаашид үргэлжлүүлэн байлгахгүй байх тухай заасан өөр төрлийн хуулбар зэрэг орно.
4. Энэ зүйлд заасны дагуу шилжүүлэн өгөх этгээдийг шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн бөгөөд эдлүүлэхээр төлөвлөгдөж байгаа оноосон ялтай холбоогүй гэмт хэрэгт холбогдуулан түүнийг хянан шалгах, ял оноох, эсхүл саатуулахыг, эсхүл



дараах тохиолдлоос бусад үед түүний хувийн эрх чөлөөг ямар нэгэн байдлаар хязгаарлахыг хориглоно. Үүнд:

(a) Ял оноосон оролцогч улс зөвшөөрсөн байх. Ингэхдээ:

(i). уг зөвшөөрлөө холбогдох бусад баримт бичиг болон ялтан этгээдээс өгсөн мэдүүлгийн хууль ёсны тэмдэглэлийг хамт ирүүлсэн байна;

(ii). уг зөвшөөрлийг ял оноосон оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгдөг гэмт хэргийн төрөлд хамаардаг, эсхүл ял эдлэх хугацаанаас хамаарч шилжүүлэн өгөөгүй тохиолдолд тус тус олгоно;

(b) ялтан этгээд ял эдлүүлэх оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарах боломжтой байсан ч суллагдсанаас хойш 45 хоногийн дотор энэ боломжийг ашиглаагүй, эсхүл тус улсын нутаг дэвсгэрээс гараад эргэн ирсэн байх зэрэг хамаарна.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн заалтыг үл харгалзан ял эдлүүлэх оролцогч улс дотоодын хууль тогтоомжийн дагуу хугацаа алдсанаас гарах аливаа эрх зүйн үр дагавраас урьдчилан сэргийлэх үүднээс хэргийг хянан шийдвэрлэх in absentia зарчмаар ажиллагааг эхлүүлэх зэрэг шаардлагатай аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

6. Энэ зүйлд дурдсан нөхцөл байдал үүсэх үед аль нэг оролцогч улс ял эдлүүлэх үүргийг шилжүүлэн авах тухай заасан заалт энэ зүйлд ороогүй болно.

73 дугаар зүйл. Ялтан шилжүүлэхэд ял оноосон оролцогч улсын хувьд үүсэх үр дагавар


1. Ял эдлүүлэх оролцогч улсын эрх бүхий байгууллага ялтныг хүлээн авснаар түүний ялыг ял оноосон улсад албадан хэрэгжүүлэхийг зогсоосон гэж тооцно.
2. Ял эдлүүлэх оролцогч улс ялыг бүрэн эдэлсэн гэж үзэх тохиолдолд ял оноосон улс тухайн ялыг албадан хэрэгжүүлэхийг шаардах эрхгүй болно.

74 дүгээр зүйл. Ялтан шилжүүлэхэд ял эдлүүлэх оролцогч улсын хувьд үүсэх үр дагавар

1. Ял эдлүүлэх оролцогч улсын эрх бүхий байгууллага нь:

(a) 75 дугаар зүйлд заасны дагуу ялыг нэн даруй, эсхүл шүүхийн болон захиргааны шийдвэрээр үргэлжлүүлэн албадан хэрэгжүүлнэ; эсхүл

(b) шүүхийн, эсхүл захиргааны журмаар ялыг хөрвүүлэн тооцно. Ингэхдээ ял оноосон оролцогч улсад тогтоосон шийтгэлийг тухайн ял эдлүүлэх улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу ижил төрлийн гэмт хэргт оноодог шийтгэлээр 76 дугаар зүйлд нийцүүлэн орлуулна.




2. Аль ч оролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээний аль нэгийг оролцогч нөгөө улсын хувьд хэрэглэхгүй байж болох бөгөөд энэ талаар оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагад, хэрэв 85 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан нөхцөл үүсэн бол нэмэлт дэмжлэг үзүүлэхээр түр томилогдсон улсад тус тус мэдээлнэ.
3. Хэрэв хүсэлт гаргасан бол ял эдлүүлэх оролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээний алиныг авч хэрэгжүүлэх талаар ялтан шилжүүлэн авахаас өмнө ял оноосон оролцогч улсад мэдэгдэнэ.
4. Ялын шийтгэлийг ял эдлүүлэх оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу албадан хэрэгжүүлэх бөгөөд зөвхөн тухайн оролцогч улс уг ялын хэрэгжилттэй холбоотойгоор шийдвэр гаргах үүрэг хүлээнэ.
5. Оролцогч аль нэг улс өөрийн дотоодын хууль тогтоомжоор сэтгэцийн эрүүл мэндийн байдлын улмаас эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн хариуцлагаас чөлөөлөгдсөн этгээдэд оролцогч нөгөө улс оноосон арга хэмжээг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан журмаар албадан хэрэгжүүлэхийг зөвшөөрдөггүй ба хариуцлагаас чөлөөлөгдсөн эдгээр этгээдийг эмчилгээний зорилгоор хүлээн авахаар бэлдэж байгаа бол тухайн оролцогч улс нь авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар оролцогч бусад улсын эрх бүхий төв байгууллагад, хэрэв 85 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн бол нэмэлт дэмжлэг үзүүлэхээр түр томилогдсон улсад мэдээлнэ.

75 дүгээр зүйл. Ялыг үргэлжлүүлэн албадан хэрэгжүүлэх

1. Ялыг үргэлжлүүлэн албадан хэрэгжүүлж байгаа тохиолдолд ял эдлүүлэх улс ял оноосон улсын зүгээс тогтоосон тухайн ялын эрх зүйн шинж чанар болон хугацааг мөрдлөг болгоно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан ялын шинж чанар болон хугацаа нь ял эдлүүлэх улсын дотоодын хууль тогтоомжтой нийцэхгүй байгаа, эсхүл дотоодын хууль тогтоомжийн дагуу шаардаж байгаа бол ял эдлүүлэх улс албадан хэрэгжүүлэх ёстой тухайн ялын шийтгэлийг шүүхийн, эсхүл захиргааны журмаар гаргасан шийдвэрийн дагуу ижил төрлийн гэмт хэрэгт тухайн улсын дотоодын хууль тогтоомжид зааснаар оногдуулдаг шийтгэл, эсхүл арга хэмжээнд дүйцүүлэн тохируулж болно. Ийнхүү тохируулсан шийтгэл, эсхүл арга хэмжээ нь шинж чанарын хувьд албадан хэрэгжүүлэх ёстой байсан ялын шийтгэлтэй аль болох нийцэж байх шаардлагатай. Түүнчлэн уг шийтгэлийг шинж чанар, хугацааны хувьд өмнө оноосон ялын шийтгэлээс илүү хүнд болгож, эсхүл ял эдлүүлэх улсын дотоодын хууль тогтоомжид заасан ялын дээд хэмжээнээс хэтрүүлж тогтоохыг хориглоно.

76 дугаар зүйл. Ялыг хөрвүүлэн тооцох

1. Ялыг хөрвүүлэн тооцож байгаа тохиолдолд ял эдлүүлэх оролцогч улсын



дотоодын хууль тогтоомжид заасан журмыг хэрэглэнэ. Ялыг хөрвүүлэхэд эрх бүхий байгууллага нь:

- a) ял оноосон оролцогч улсад гаргасан шүүхийн шийдвэрт шууд, эсхүл шууд бус хэлбэрээр тогтоосон баримтын талаарх дүгнэлтийг мөрдлөг болгоно;
 - b) эрх чөлөөг хязгаарлах шийтгэлийг мөнгөн торгууль болгон хөрвүүлэхгүй;
 - c) тухайн ялтны эрх чөлөөгөө хязгаарлуулж, нийт эдэлсэн ялын хугацааг тооцож, хасна;
 - d) ял этгээдийн шийтгэлийг хүндрүүлэхгүй;
 - e) ял эдлүүлэх оролцогч улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу тухайн гэмт хэрэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг үйлдэхэд оноодог ялын доод хэмжээг мөрдлөг болгохгүй.
2. Хэрэв ялтанг шилжүүлэн авсны дараа ялыг хөрвүүлэн тооцох ажиллагаа явагдаж байгаа бол ял эдлүүлэх оролцогч улс уг ажиллагаа дуусах хүртэл тухайн ялтан этгээдийг үргэлжлүүлэн хорьж, эсхүл түүнийг өөрийн нутаг дэвсгэрээс гаргахгүй байх талаар өөр төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

77 дугаар зүйл. Ялын тогтоолыг эргэн харах

Ял оноосон оролцогч улс тухайн улсад гаргасан ялын тогтоолыг эргэн хянах талаар гаргасан аливаа хүсэлтийг дангаар шийдвэрлэнэ.

78 дугаар зүйл. Ялыг албадан хэрэгжүүлэхийг зогсоох


Ял оноосон оролцогч улс тухайн ялыг цаашид албадан хэрэгжүүлэхгүй байх талаар гаргасан шийдвэр, эсхүл авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай ял эдлүүлэх оролцогч улсад мэдээлсэн бол тухайн ял эдлүүлэх оролцогч улс ялыг албадан хэрэгжүүлэх ажиллагаагаа зогсооно.

79 дугаар зүйл. Ялыг албадан хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл


Ял эдлүүлэх оролцогч улс ялыг албадан хэрэгжүүлж байгаа талаар дараах тохиолдолд ял оноосон улсад мэдээлнэ. Үүнд:

- (a) ялыг албадан хэрэгжүүлэх хугацаа дуусгавар болсон гэж үзэх;
- (b) ялыг албадан хэрэгжүүлэх хугацаа дуусгавар болохоос өмнө ялтан этгээд хорих газраас оргон зайлах;
- (c) ял оноосон улсын зүгээс тусгай тайлан ирүүлэхийг хүсэх зэрэг хамаарна.

80 дугаар зүйл. Ялтан этгээдийг дамжин өнгөрүүлэх



1. Оролцогч улс ялтан этгээдийг шилжүүлэх өгөх, эсхүл шилжүүлэн авах талаар оролцогч өөр улс, эсхүл гуравдагч улстай тохиролцсон бөгөөд тухайн этгээдийг нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх талаар оролцогч нөгөө улсад хүсэлт гаргасан бол холбогдох оролцогч улс дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн уг хүсэлтэд зөвшөөрөл олгоно.
2. Хэрэв ялтан этгээд тухайн оролцогч улсын харьяат бол холбогдох оролцогч улс түүнийг дамжин өнгөрүүлэхээс татгалзаж болно.
3. Дамжин өнгөрөх хүсэлт болон түүний хариуг 21 дүгээр зүйлийн 1, эсхүл 2 дахь хэсэгт заасан харилцах сувгаар дамжуулна.
4. Оролцогч улс ялтан этгээдийг нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрүүлэх хүсэлтийг гуравдагч улсаас хүлээн авсан ба тухайн гуравдагч улс ялтан шилжүүлэн авах, эсхүл шилжүүлэн өгөх талаар оролцогч өөр улстай тохиролцсон байгаа тохиолдолд холбогдох хүсэлтийг зөвшөөрч болно.
5. Дамжин өнгөрөх хүсэлт хүлээн авсан оролцогч улс тухайн ялтан этгээдийг зөвхөн өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд шаардлагатай хугацаанд хорин саатуулж болно.
6. Ял оноосон оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарахаас өмнө үйлдэгдсэн аливаа гэмт хэрэг, эсхүл хүлээсэн ял шийтгэлтэй холбогдуулан тухайн ялтан этгээдийг дамжин өнгөрөх улсын нутаг дэвсгэр дээр мөрдөн шалгах, эсхүл энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд түүнийг хорих, эсхүл хувийн эрх чөлөөг нь өөр байдлаар хязгаарлахгүй байх талаар баталгаа гаргаж өгөхийг дамжин өнгөрөх хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас хүсэж болно.
7. Оролцогч улсын нутаг дэвсгэрээр дамжин агаарын хөлгөөр тээвэрлэж, төлөвлөсөн буулт хийхгүй бол дамжин өнгөрөх хүсэлт гаргах шаардлагагүй. Нутаг дэвсгэрээр нь дамжин ийнхүү тээвэрлэх тохиолдолд энэ талаар мэдэгдэж байхыг тухайн оролцогч улс бусад оролцогч улсын эрх бүхий төв байгууллагад, эсхүл 85 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасан нөхцөл үүссэн бол нэмэлт дэмжлэг үзүүлэхээр түр томилогдсон улсад хандан шаардаж болно.
8. Төлөвлөгөөт бус буулт хийсэн тохиолдолд 65 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт *mutatis mutandis* зарчмаар үйлчилнэ.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХОХИРОГЧ, ГЭРЧ, ШИНЖЭЭЧ БОЛОН БУСАД ЭТГЭЭД

81 дүгээр зүйл. “Хохирогч” нэр томъёоны тодорхойлолт

1. Дотоодын хууль тогтоомжид заасан өргөн хүрээтэй тодорхойлолтод харшлахгүйгээр, конвенцын энэ бүлгийн зорилтод нийцүүлэн:

- а) “хохирогч” гэж энэхүү конвенцод хамаарах аливаа гэмт хэрэг үйлдсэний улмаас хохирол амссан хувь хүнийг;
- б) “хохирогч” гэдэгт шашин, боловсрол, урлаг, шинжлэх ухаан, буяны үйл хэрэгт зориулагдсан эд хөрөнгөд нь, эсхүл хүмүүнлэгийн зорилгоор ашиглагдаж байгаа харьяа түүхийн дурсгалт газар, эмнэлэг, бусад газар, объектод нь шууд хохирол учирсан аливаа байгууллага, институцыг тус тус хамруулна.

2. Энэ зүйлийн заалтыг дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн мөрдөнө.

82 дүгээр зүйл. Хохирогч, гэрч, шинжээч болон бусад этгээдийг хамгаалах


1. Оролцогч улс бүр мөрдөн шалгах, хянан шалгах, эсхүл энэхүү конвенцын хүрээнд явуулж буй бусад ажиллагаанд оролцож, эсхүл хамтран ажиллаж байгаа хохирогч, гэрч болон зохих тохиолдолд тэдгээрийн хамаарал бүхий этгээд, бие төлөөлөгч, шинжээч болон бусад этгээдийг болзошгүй өс хонзон, сүрдүүлэг, зүй бус харилцаанаас үр дүнтэй хамгаалах талаар өөрийн нөөц бололцооны хүрээнд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2. Шударга шүүхээр хэргээ хянан шийдвэрлэх зэрэг хариуцагчийн эрхийг хөндөхгүйгээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан арга хэмжээнд дараах зүйлийг хамруулж болно. Үүнд:

(а) энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдийг шаардлагатай бөгөөд боломжтой тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, тэдний хувь хүний болон байршлын талаарх мэдээллийг хаах, эсхүл хязгаарлах зэрэг биетээр хамгаалах тухай журам тогтоох;


(б) хохирогч, гэрч ба шинжээчийн аюулгүй байдлаа хангуулсны үндсэн дээр мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх, зохих тохиолдолд тэдний биеийн болон сэтгэл санааны эрүүл мэндийг хамгаалах, хувийн нууцыг хадгалах үүднээс харилцаа холбооны технологийг ашиглах тухай журам тогтоох зэрэг болно.

3. Оролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдүүдийг нүүлгэн шилжүүлэх асуудлаар оролцогч нөгөө улстай хэлэлцээр, эсхүл тохиролцоо байгуулах боломжийг судалж үзнэ.



83 дугаар зүйл. Хохирогчийн эрх

1. Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчийн нөхөн сэргээлгэх, нөхөн төлбөр авах, эсхүл цагаатгуулах зэрэг хүлээсэн хохирлоо барагдуулах эрхийг дараах тохиолдолд хангана. Үүнд:
 - а) гэмт хэргийг тухайн оролцогч улсын харьяаллын нутаг дэвсгэрийн аль нэг хэсэг дээр үйлдсэн; эсхүл
 - б) тухайн оролцогч улс гэмт хэргийг өөрийн харьяалалд оруулсан байх зэрэг болно.
2. Хариуцагч талын эрхийг хөндөхгүйгээр сэжигтэн этгээдийн эсрэг үүсгэсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэр холбогдох шатанд хохирогчийг оролцуулахыг зөвшөөрөх, түүний үзэл бодол болон анхааруулгыг сонсож, харгалзан үзэж байх боломжийг бүрдүүлэх зорилгоор оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийн дагуу журам тогтооно.
3. Оролцогч улс бүр хүсэлт гаргасан улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү конвенцод хамаарах гэмт хэргийн хохирогчийн хохирлоо нөхөн сэргээлгэх, нөхөн төлбөр авах, эсхүл цагаатгуулах талаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гаргасан шүүхийн шийдвэр, эсхүл тогтоолыг тус тусын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон хэмжээнд болон энэ талаар хүсэлт хүлээн авсны дагуу хүчин төгөлдөр болгоно.




ДОЛООДУГААР БҮЛЭГ : ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

84 дүгээр зүйл. Оролцогч улсын уулзалт


1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн дараа, эсхүл энэхүү конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох тухай 15 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 2 жилийн дараа буюу энэ хоёр хугацааны хамгийн сүүлчийнхийг сонгон оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувийн саналаар оролцогч улсын анхны уулзалтыг зохион байгуулна.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан оролцогч улсын уулзалтын үеэр оролцогч улсууд:
 - а) 87 дугаар зүйлд заасны дагуу санал болгосон энэхүү конвенцод оруулах нэмэлт өөрчлөлт болон 88 дугаар зүйлд заасны дагуу санал болгосон нэмэлт хавсралтыг авч хэлэлцэнэ;
 - б) НҮБ-ын албан ёсны хэл дээрх үйлдсэн энэхүү конвенцтой холбоотой бусад жинхэнэ эх бичвэрийг авч хэлэлцэнэ;
 - в) 85 дугаар зүйлд заасан арга хэмжээг хамруулан энэхүү конвенцыг хэрэгжүүлэхэд шаардагдах хэмнэлттэй бөгөөд зардал багатай зохион байгуулалтын бүтэц бий болгох талаар авч хэлэлцэнэ.
3. Оролцогч улсуудын биечлэн уулзах арга хэмжээнээс тусдаа ба түүнд нөлөөлөхгүйгээр, оролцогч улсын оролцох, өөр хоорондоо харилцах болон зөвлөлдөхийг аль болох өргөжүүлэхийг дэмжих үүднээс боломжтой үед харилцааны цахим хэрэгслийг ашиглаж, видео хурал зохион байгуулна.

85 дугаар зүйл. Шилжилтийн үеийн дэмжлэг

1. Нидерландын Хаант Улс 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан мэдээллийг энэхүү конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох арван тав дахь баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш хоёр жилийн дотор аль болох богино хугацаанд эмхэтгэж, ажлын хэрэгцээнд зориулан бэлэн болгоно.
2. Нидерландын Хаант Улс дараах шилжилтийн үеийн дэмжлэгийг нэмэлт байдлаар үзүүлж болно. Үүнд:
 - а) 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 74 дүгээр зүйлийн 2 болон 5 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт тус тус дурдсан мэдээллийг эмхэтгэж, ажлын хэрэгцээнд зориулан бэлэн болгох;



- b) 84 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан оролцогч улсын анхны уулзалтыг зохион байгуулах зэрэг болно.
3. Энэ зүйлийн 2 дэх хэсэгт дурдсан нэмэлт байдлаар үзүүлэх шилжилтийн үеийн дэмжлэг нь холбогдох зардлыг төлөх үүднээс оролцогч улсуудын зүгээс сайн дураар өгсөн санхүүгийн хандивын сан бүрдэх эсэхээс хамаарч болно.



НАЙМДУГААР БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

86 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

1. Оролцогч улс энэхүү конвенцыг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотой гарсан аливаа маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
2. Хоёр болон түүнээс дээш оролцогч улсын хооронд энэхүү конвенцыг тайлбарлах, эсхүл хэрэглэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг түүнийг шийдвэрлэх санал гарснаас хойш зургаан сарын дотор хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд аль нэг оролцогч улсын хүсэлтээр арбитрын шүүхэд хандана. Хэрэв арбитрын шүүхэд хандах хүсэлт гаргасан өдрөөс хойш зургаан сарын дотор оролцогч улс арбитрын шүүхийн ажиллагааг зохион байгуулах талаар хоорондоо тохиролцоонд хүрч чадаагүй бол эдгээр оролцогч улсын аль нэг нь Олон улсын шүүхийн дүрмийн дагуу хүсэлт гаргаж, маргааныг Олон улсын шүүхэд шилжүүлэхээр хандаж болно.
3. Оролцогч улс энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах, эсхүл нэгдэн орохдоо энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу үүрэг хүлээхгүй гэдгээ мэдэгдэж болно. Ийм тайлбар хийсэн аливаа оролцогч улсын тухайд бусад оролцогч улс энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу үүрэг хүлээхгүй.

87 дугаар зүйл. Конвенцын нэмэлт, өөрчлөлт

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн дараа, эсхүл энэхүү конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох тухай 15 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрийн дараа буюу энэ хоёр хугацааны хамгийн сүүлчийнхийг сонгон оролцогч улс энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргаж болно.
2. Нэмэлт, өөрчлөлт оруулах аливаа саналыг эх хадгалагчид хүргүүлэх бөгөөд эх хадгалагч тухайн саналыг оролцогч улсын ээлжит уулзалтаар хэлэлцэн шийдвэрлүүлэх зорилгоор оролцогч бүх улсад хүргүүлнэ. Эх хадгалагч тухайн санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг энэхүү конвенцод гарын үсэг зурсан болон нэгдэн орж байгаа улсад хүргүүлнэ.
3. Оролцогч улсууд энэхүү конвенцод оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтийн талаар зөвшилцөлд хүрэх үүднээс бүх талын хүчин чармайлт гаргана. Хэрэв зөвшилцөлд хүрэх бүх боломжийг ашигласан бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хамгийн сүүлийн хувилбар бол энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан оролцогч улсын уулзалтад оролцож, санал өгсөн оролцогч улсын дөрөвний гурвын саналаар батална. Энэхүү зүйлийн зорилгод нийцүүлэн уулзалтад оролцож, санал өгсөн оролцогч улс гэж уулзалтад оролцож, дэмжсэн, эсхүл дэмжээгүй аль нэг санал өгсөн оролцогч улсыг ойлгоно.
4. Эх хадгалагч батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлуулах, зөвшөөрүүлэх, эсхүл батлуулах зорилгоор оролцогч улсууд, энэхүү конвенцод нэгдэн орж байгаа



болон конвенцод гарын үсэг зурсан талуудад эдгээр нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлнэ.

5. Нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсууд эдгээр нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр болсны дараа биелүүлэх үүрэг хүлээнэ. Оролцогч бусад улсын хувьд энэхүү конвенцыг заалтууд болон дагаж мөрдөхийг өмнө нь зөвшөөрсөн нэмэлт өөрчлөлтүүд хэвээр үйлчилнэ.

6. Нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай гурав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сарын өнгөрсний дараа шинээр эхлэх сарын эхний өдрөөс эхлэн тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай гурав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсний дараа уг нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл баталж байгаа бол тухайн оролцогч улсын хувьд уг нэмэлт өөрчлөлт нь тухайн улс соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш 3 сар өнгөрсний дараа эхлэх сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

88 дугаар зүйл. Нэмэлт хавсралт батлах

1. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 5 жилийн дараа, эсхүл энэхүү конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орох тухай 15 дахь баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрийн дараа буюу энэ хоёр хугацааны хамгийн сүүлчийнхийг сонгон аливаа оролцогч улс энэхүү конвенцын бусад нэмэлт хавсралтад ороогүй байгаа олон улсын нэг, эсхүл түүнээс дээш гэмт хэргийг багтаасан шинэ нэмэлт хавсралтыг санал болгож болно.


2. Нэмэлт хавсралтыг санал болгох, батлах болон хүчин төгөлдөр болгохдоо 87 дугаар зүйлийн 2-оос 6 хүртэлх хэсэгт заасан журмыг баримтална.

89 дүгээр зүйл. Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах болон нэгдэн орох

1. Энэхүү конвенц нь 2024 оны 2 дугаар сарын 14 болон 15-ны өдөр Гааг хотын Энх тайвны ордонд аль ч улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна. Үүний дараа буюу 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл Брюссель хотод Бельгийн Хаант Улсын Холбооны гадаад харилцаа, гадаад худалдаа, хөгжлийн хамтын ажиллагааны төрийн албаны газарт гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү конвенцыг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл батална. Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулахаар өгнө.

3. Аль ч улс энэхүү конвенцод нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулахаар өгнө.



90 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай гурав дахь баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сар өнгөрсний дараа эхлэх сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно
2. Энэхүү конвенцыг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай гурав дахь баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон улсын хувьд энэхүү конвенц нь тухай улс соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гурван сар өнгөрсний дараа эхлэх сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно.
3. Энэхүү конвенцыг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орохдоо 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хийсэн мэдэгдэл нь энэ зүйлийн 1, эсхүл 2 дахь хэсэгт заасан журмын дагуу тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн үйлчилнэ.
4. Энэхүү конвенцыг хүчин төгөлдөр болохоос өмнө түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсны дараагаар 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргасан мэдэгдэл нь энэ зүйлийн 1, эсхүл 2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн үйлчилнэ. Хэрэв энэхүү конвенц холбогдох улсын хувьд хүчин төгөлдөр болсон бол тухайн мэдэгдэл нь түүнийг эх хадгалагчид хүргүүлсэн өдрөөс хойш гурван сар өнгөрсний дараа эхлэх сарын эхний өдөр эхлэн үйлчилнэ.
5. Энэхүү конвенц нь тухайн оролцогч улсын хувьд энэхүү конвенц, эсхүл нэмэлт хавсралт хүчин төгөлдөр болох өдрөөс дараа гаргасан бөгөөд ийнхүү хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө гарсан үйлдэл, эс үйлдэл зэрэгт хамаарах аливаа хүсэлтэд үйлчилнэ. Энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл нэгдэн орохдоо, эсхүл энэхүү конвенцын нэг буюу түүнээс дээш нэмэлт хавсралтыг хэрэгжүүлэх талаар мэдэгдлийг эх хадгалагчид хүргүүлэхдээ аливаа оролцогч улс түүний хувьд энэхүү конвенц, эсхүл холбогдох нэмэлт хавсралт хүчин төгөлдөр болохоос өмнө бөгөөд тухайн улсын зүгээс тодорхойлсон аль нэг өдрөөс өмнө гарсан үйлдэл, эс үйлдэлд хамаарах хүсэлтэд энэхүү конвенцыг хэрэглэхгүй байх эрхтэй болохоо эх хадгалагчид мэдэгдэж болно.

91 дүгээр зүйл. Түр хугацаагаар хэрэгжүүлэх

1. Энэхүү конвенцод гарын үсэг зурах үед аливаа улс түүний хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болох өдөр хүртэл энэхүү конвенцыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар хэрэгжүүлэхээ мэдэгдэж болно.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл гаргаагүй бөгөөд энэхүү конвенцын оролцогч тал хараахан болоогүй байгаа улсууд энэхүү конвенцыг түр



хугацаагаар хэрэгжүүлж байгаа аль нэг улсаас хамтран ажиллах талаар хүсэлт гаргах тохиолдолд уг хүсэлтэд татгалзсан хариу өгч болно.

3. Энэхүү конвенцод гарын үсэг зурсан аливаа улс эх хадгалагчид бичгээр мэдэгдэл хүргүүлснээр энэхүү конвенцыг түр хугацаагаар хэрэгжүүлэхээ зогсоож болно. Энэхүү конвенцын түр хугацаагаар хэрэгжүүлэхээ зогсоох тухай шийдвэр нь эх хадгалагч мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш шинээр эхлэх сарын эхний өдөр хүчин төгөлдөр болно. Түр хугацаагаар хэрэгжүүлэхээ зогсоох нь ийнхүү зогсоохоос өмнө энэхүү конвенцын дагуу гаргасан хүсэлттэй холбоотойгоор тухайн улсын зүгээс хүлээж байсан аливаа үүргийг хөндөхгүй.

92 дугаар зүйл. Тайлбар хийх


1. Энэ зүйлд зааснаас өөр байдлаар энэхүү конвенцод тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.
2. Энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орохдоо аливаа улс 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйл, 42 дугаар зүйлд тайлбар хийх эсэхээ, мөн 86 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон 90 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт шууд заасны дагуу тайлбар хийхээ мэдэгдэж болно.
3. Энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орохдоо аль нэг улс дотоод хууль тогтоомжид байгаа үндэслэл болон олон улсын эрх зүйн хүрээнд тус улсын зүгээс хэргийн харьяалал тогтоохыг хязгаарлах талаар 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасантай нийцүүлэн 3 жил тутам шинэчлэгдэж байх тайлбар хийхээ мэдэгдэж болно.
4. Энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа улс эх хадгалагчид мэдэгдэл хүргүүлснээр тухайн хийсэн тайлбараа хэдийд ч цуцалж болно.

93 дугаар зүйл. Конвенцоос гарах

1. Оролцогч улс эх хадгалагчид мэдэгдэл хүргүүлснээр энэхүү конвенцоос гарч болно.
2. Конвенцоос гарах нь эх хадгалагч мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дараа, үүнээс хойш бол тухайн мэдэгдэлд заасан өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр болно.
3. Конвенцоос гарах нь түүний энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө энэхүү конвенцын дагуу гаргасан хүсэлттэй холбоотойгоор энэхүү конвенцын дагуу тухайн улсын хүлээсэн үүргийг хөндөхгүй.
4. Оролцогч улс 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг заасны дагуу гаргасан мэдэгдлээ эх хадгалагчид мэдэгдэл хүргүүлснээр цуцалж болно. Ийнхүү цуцлах нь энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт тогтоосон журмын дагуу хүчин төгөлдөр болно.

94 дүгээр зүйл. Эх хадгалагч болон хэл

1. Бельгийн Хаант Улс нь энэхүү конвенц болон түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн эх хадгалагч байна.



2. Адил хүчинтэй байх англи, франц болон испани хэлээрх энэхүү конвенцын эх хувь болон 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан бусад хэлээрх эх хувийг эх хадгалагчид хадгалуулна.

3. Эх хадгалагч нь:

- а) энэхүү конвенцын албан ёсны эх бичвэр болон 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан бусад эх бичвэрийг хадгална.
- б) энэхүү конвенцын албан ёсны эх бичвэрийн болон 84 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн (b) дэд хэсэгт дурдсан бусад эх бичвэрийн баталгаажуулсан хуулбарыг бэлтгэж, оролцогч улсууд болон энэхүү конвенцын оролцогч тал болох эрхтэй болох улсад тэдний хүсэлтийн дагуу хүргүүлнэ.
- c) энэхүү конвенцыг НҮБ-ын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ.

4. Эх хадгалагч нь оролцогч улс, нэгдэн орж байгаа улс болон гарын үсэг зурсан улсад дараах зүйлийг мэдэгдэнэ. Үүнд:

- а) 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенцын хавсралтад тусгагдсан нэг буюу хэд хэдэн гэмт хэрэг энэхүү конвенцын үйлчлэх хүрээг тэлж, түүнд хамаарах болсон талаарх аливаа мэдэгдэл;
- б) 9 дүгээр зүйлд заасны дагуу "харьяат" гэсэн нэр томъёоны тодорхойлолтын талаарх аливаа мэдэгдэл;
- с) 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий төв байгууллагыг томилсон талаарх аливаа мэдэгдэл;
- д) 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу харилцах сувгийн талаарх аливаа мэдэгдэл;
- е) 86 дугаар зүйлийн 3 дэх хэсэгт заасны дагуу маргаан шийдвэрлэхтэй холбоотой аливаа мэдэгдэл;
- f) энэхүү конвенцод оруулсан нэмэлт өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүлээн авсан тухай мэдээлэл болон энэхүү конвенцод оруулсан нэмэлт өөрчлөлт 87 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болох огноо;
- g) 89 дүгээр зүйлд заасны дагуу соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар хүлээн авсан тухай мэдээлэл;
- h) 90 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү конвенц хүчин төгөлдөр болох огноо;
- i) энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа 90 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох оролцогч улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болох огноо;
- j) 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү конвенцыг түр хугацаагаар хэрэгжүүлэх тухай аливаа мэдэгдэл;
- к) 91 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү конвенцын түр хэрэгжүүлэхээ зогсоох тухай аливаа мэдэгдэл;



- l) 92 дугаар зүйлийн дагуу хийсэн аливаа тайлбар;
- m) 93 дугаар зүйлийн 1 болон 4 дэх хэсэгт заасны дагуу конвенцоос гарсан тухай аливаа мэдэгдэл.

ДЭЭРХИЙГ НОТЛОН тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү конвенцод гарын үсэг зурав.


Любляна хотноо 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр үйлдэв.



Хавсралт
Хавсралт А. Дайны гэмт хэрэг

Энэхүү конвенцод 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (е) дэд хэсэгт заасан үйлдлүүдээс гадна оролцогч улсаас 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн дараах үйлдлүүд хамаарна.

- a) Хор, хордуулах зэвсэг хэрэглэх;
- b) Амьсгал боогдуулах, хортой болон бусад хий, түүнтэй адилтгах бүх шингэн, материал, төхөөрөмж хэрэглэх;
- c) Хүний биед нэвт орсноор тэлдэг, эсхүл хавтгай болдог, цөм нь бүхэлдээ хатуу гадаргуугүй, эсхүл нүхэлсэн сум хэрэглэх.




Хавсралт В. Дайны гэмт хэрэг

Энэхүү конвенцод 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (b) дэд хэсэг, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (e) дэд хэсэгт заасан үйлдлүүдээс гадна оролцогч улсаас 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн дараах үйлдлүүд хамаарна. Үүнд: Гарал үүсэл, үйлдвэрлэлийн аргаас үл хамааран бичил биетний болон бусад биологийн бодис, хорт бодист зэвсэг хэрэглэх.



Хавсралт С. Дайны гэмт хэрэг

Энэхүү конвенцод 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (b) дэд хэсэг, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (e) дэд хэсэгт заасан үйлдлүүдээс гадна оролцогч улсаас 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн дараах үйлдлүүд хамаарна. Үүнд: Рентген туяагаар илрүүлэх боломжгүй, хүний биеийг хэлтэрхийгээр гэмтээх үр нөлөөтэй зэвсэг хэрэглэх.




Хавсралт D. Дайны гэмт хэрэг

Энэхүү конвенцод 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (b) дэд хэсэг, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (e) дэд хэсэгт заасан үйлдлүүдээс гадна оролцогч улсаас 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн дараах үйлдлүүд хамаарна. Үүнд: Хүний нүд, эсхүл хараа засах хэрэгслийг нөлөөлөх замаар хараагүй болгоход тусгайлан бүтээсэн лазер туяат зэвсгийг дан байлдааны, эсхүл байлдааны аль нэг зорилгоор хэрэглэх.




Хавсралт Е. Дайны гэмт хэрэг

Энэхүү конвенцод 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн (е) дэд хэсэгт заасан үйлдлүүдээс гадна оролцогч улсаас 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдсэн дараах үйлдлүүд хамаарна. Үүнд: Байлдааны арга болгон иргэдийн амьдрахад зайлшгүй шаардлагатай зүйлсээс нь салгах, хүмүүнлэгийн тусламжийн нийлүүлэлтийг зориудаар саатуулах зэргээр санаатайгаар өлсгөх.




Хавсралт F. Эрүү шүүлт тулгах

1. Энэхүү конвенцод 5 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдээс гадна 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсаас мэдэгдсэн эрүү шүүлтийн гэмт хэрэгт хамаарна.
2. Энэхүү конвенцод "эрүүдэн шүүх" гэж нийтийн албан тушаалтан өөрөө, эсхүл албаны чиг үүргийг гүйцэтгэгч бусад этгээд хүнээс, эсхүл гуравдагч этгээдээс мэдээлэл, эсхүл мэдүүлэг авах, эсхүл тухайн хүний, эсхүл гуравдагч этгээдийн үйлдэл, эсхүл болзошгүй үйлдлийн төлөө шийтгэх, эсхүл ялгаварлан гадуурхах шалтгаанаар айлган сүрдүүлэх зорилгоор хүний биеэ, сэтгэл санааг өвтгөх, зовоох үйлдлийг хэлнэ. Хууль ёсны санкцаас, эсхүл түүнээс болж өвдөх, эсхүл зовох явдал эрүү шүүлт тулгахад орохгүй.



Хавсралт G. Хүчээр алга болгох

1. Энэхүү конвенцод 5 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдээс гадна 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсаас мэдэгдсэн хүчээр алга болгох гэмт хэрэгт хамаарна.
2. Энэхүү конвенцод "хүчээр алга болгох" гэж төрийн албан хаагчид, эсхүл төрөөс эрх олгогдсон, дэмжлэг авсан, хүлээн зөвшөөрөгдсөн бүлэг этгээдийн баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл ямар нэгэн байдлаар эрх чөлөө хязгаарлах үйлдлийг хэлнэ ба ингэхдээ тухайн этгээдийн эрх чөлөө хязгаарлагдсаныг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, эсхүл алга болсон хүний хувь буюу байршлыг нуун дарагдуулах замаар хуулийн хамгаалалтгүй болгох.



Хавсралт Н. Түрэмгийллийн гэмт хэрэг

1. Энэхүү конвенцод 5 дугаар зүйлд заасан гэмт хэргүүдээс гадна 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу оролцогч улсаас мэдэгдсэн түрэмгийллийн гэмт хэрэгт хамаарна.

2. Энэхүү конвенцод “түрэмгийллийн гэмт хэрэг” гэж төрийн эрх мэдэлтэй, эсхүл улс төр, цэргийн ажиллагааг удирдах этгээд НҮБ-ын дүрмийг зөрчин шинж чанар, нөхцөл, хамрах хүрээгээр түрэмгийлэх үйлдлийг төлөвлөх, бэлтгэх, санаачлах, эсхүл хэрэгжүүлэхийг хэлнэ.

3. 2 дахь хэсэгт заасан “түрэмгийлэх үйлдэл” гэж улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн хараат бус байдлын эсрэг, эсхүл НҮБ-ын дүрэмд харшлах бусад хэлбэрээр зэвсэгт хүчин хэрэглэхийг хэлнэ. Дайн зарласнаас үл хамааран дор дурдсан бүх үйлдэл нь 1974 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 3314 (XXIX) дугаар тогтоолын дагуу түрэмгийлэх үйлдэлд хамаарна: Үүнд:

а) аль нэг улсын зэвсэгт хүчин өөр улсын нутаг дэвсгэрт халдан довтлох, эсхүл тухайн халдлага, довтолгоотой холбоотойгоор түр хугацаагаар нутаг дэвсгэрийг цэргийн хүчээр эзлэх, эсхүл өөр улсын нутаг дэвсгэр, түүний хэсгийг нь хүч хэрэглэн өөртөө нэгтгэх;

б) аль нэг улсын зэвсэгт хүчин өөр улсын нутаг дэвсгэрийг бөмбөгдөх, эсхүл аль нэг улс өөр улсын нутаг дэвсгэрийн эсрэг аливаа зэвсэг хэрэглэх;

в) аль нэг улсын зэвсэгт хүчин өөр улсын боомт, эсхүл эргийг хааж, хязгаарлах;

д) аль нэг улсын зэвсэгт хүчин өөр улсын хуурай газар, далай, агаарын хүчин, тэнгис, эсхүл агаарын хөлөгт халдах;

е) аль нэг улсын нутагт дэвсгэрт хэлэлцээрийн дагуу байрлахдаа тухайн хэлэлцээрийн нөхцөлийг зөрчих, эсхүл хэлэлцээр хүчингүй болсон байхад үргэлжлүүлэн байрлах замаар зэвсэгт хүчин хэрэглэх;

ф) аль нэг улс өөрийн нутаг дэвсгэрийг өөр улсад гуравдагч улсын эсрэг түрэмгийлэл үйлдэхэд бэлтгэх ажиллагаанд ашиглуулахыг зөвшөөрөх;

г) өөрсдийн, эсхүл улсын нэрийн өмнөөс өөр улсын зэвсэгт хүчний эсрэг дээр дурдсантай тэнцэхүйц хэмжээний хүнд үйлдлийг зэвсэгт бүлэг, хэсэг, түр цэрэг, эсхүл хөлсний цэргээр гүйцэтгүүлэхээр илгээсэн, эсхүл түүнд тодорхой хэмжээгээр оролцсон бол.

